

ГАДААД ХАРИЛЦААНЫ

СЭРГЭЭЛТ

2021-2022



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
ГАДААД БОДЛОГО

1 ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 6 НҮБ-ын индрээс дэлхий нийтийг энх тайванд уриалав
- 8 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эхлүүлснээ зарлав
- 10 Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 23 хувь бууруулна
- 12 2026 онд "COP 27" бага хурал Улаанбаатар хотноо болно
- 14 НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш Монгол Улсад айлчлав
- 18 Цөмийн зэвсэггүй бүс-30 жил
- 19 Олон улсын эмэгтэй энхийг сахиулагчид Монгол Улсад чуулав
- 22 Хөвсгөл нуурыг ЮНЕСКО-ийн хамгаалалтад оруулав

2 БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 26 Монгол Улс ШХАБ-д ажиглагч статусаа хадгална
- 28 Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нар уулзав

**3 ХӨРШ ОРНУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

- 32 Оросын Холбооны Улсад төрийн айлчлал хийв
- 36 Бүгд Найрамдах Хятад Ард Улсад төрийн айлчлал хийв

4 ГУРАВДАГЧ ХӨРШИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 44 Япон Улсад төрийн айлчлал хийв
- 48 28 жилийн дараа биелсэн амлалт
- 52 Монгол, Япон, би, 50 дурсамж
- 54 Нийслэлчүүд ундны цэвэр усны 100 жилийн баталгаат эх үүсвэртэй болно
- 56 Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцааг нэг шат ахиулав
- 60 Солонгос иргэдийг галын аюулаас аварсан эрэлхэг монгол залуусын түүх
- 62 Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд нислэгийн тоог нэмэгдүүлэв
- 64 Бүгд Найрамдах Чех Улстай Ойн менежментийн чиглэлээр идэвхтэй хамтран ажиллана
- 65 Чехийн монголжсон мэргэжилтнүүд
- 67 Ерөнхийлөгч Вацлав Клаус "Irish pub"-д жааз хөгжмийн концерт үзэх дөхсөн нь
- 68 Хэрэгцээт түлш, шатахуунаа дотоодоос хангах цаг ойртсоор

5 БАЙР СУУРЬ

Гадаад харилцааны сайд **Б.БАТЦЭЦЭГ**

- 78 Хоёр хөрш болон гуравдагч түнш орнуудтай тэнцвэртэй хамтын ажиллагааг улам идэвхжүүлэхэд онцгой анхаарч ажиллана

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин, судлаач, профессор **Д.БАЯРХҮҮ**

- 82 "Энх тайвны бэлгэ тэмдэг" Монгол Улс

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор **Д.ЗОЛБОО**

- 86 Ерөнхийлөгч ба гадаад бодлого

Нийтлэлч **О.ТҮВШИНДЭМБЭРЭЛ**

- 88 Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Монгол Улсын гадаад харилцааг нэн шинэ түвшинд гаргалаа



Канад Улсын Гадаад хэргийн яамны Хойд Азийн орнууд хариуцсан газрын захирал Уэлдон Эпп
2022.03.31



Япон Улсын Гадаад хэргийн сайд Хаяаши Ешимаса
2022.04.30.05.02



Британийн Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн яамны Ази, Ойрх дорнодын асуудал хариуцсан Төрийн сайд Аманда Миллинг
2022.05.12



Шведийн Хаант Улсын Риксдагийн тэргүүн дэд дарга, хатагтай Оса Линдестам
2022.05.21-25



Польш Улсын Гадаад хэргийн сайд Збигнев Рау
2022.06.04-06



ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал Др. Такеши Касай
2022.06.14



ХБНГУ-ын Холбооны Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга Эбэрхард Цорн
2022.06.16-19



БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И
2022.08.08



ЮНЕСКО-ийн Ерөнхий захирал Одри Азулей
2022.07.10-14

2022

онд
Монгол Улсад
хийгдсэн
айлчлалууд



ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров
2022.07.05



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Энхийн ажиллагаа хариуцсан орлогч Жан Пьер Лакруа
2022.06.16-06.19



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш
2022.08.08-11



БНСУ-ын Гадаад хэргийн сайд Пак Жин
2022.08.29



БНАЛАУ-ын Ерөнхий сайдын орлогч, Гадаад хэргийн сайд Салемсай Гуммасит
2022.09.04



БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх
2022.09.05-07



БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хороо /БХАТИХ/-ны дарга Ли Жяньшу
2022.09.12



Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга Жорж Ж.Фюри
2022.10.10



Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Ерөнхийлөгч А.Танака
2022.10.31





ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах, дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын хувь нэмрийг оруулах, дуу хоолойгоо хүргэхэд олон талт хамтын ажиллагаа чухал үүрэгтэй.

Монгол Улс 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагад 101 дэх гишүүнээр элсэж, бүрэн эрхт гишүүн болсноос хойш тус байгууллагын үндсэн зорилго, зарчмуудыг тууштай дэмжиж, үйл ажиллагаанд нь хувь нэмрээ оруулан идэвхтэй хамтран ажиллаж ирэв.



НҮБ-ын индрээс дэлхий нийтийг энх тайванд уриалав

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2021 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 19–28-НЫ ӨДРҮҮДЭД БОЛСОН НҮБ-ЫН ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙН 76 ДУГААР ЧУУЛГАНЫ ЕРӨНХИЙ САНАЛ ШҮҮМЖЛЭЛД ОРОЛЦОВ.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Тогтвортой хөгжлийн зорилтуудыг ханган хэрэгжүүлэх, хүн төрөлхтний өмнө тулгамдсан асуудал болох уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх хүрээнд Монгол Улс 2026 онд Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын суурь конвенцын оролцогч талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах болсныг зарлав.

Тус хурлыг зохион байгуулснаар олон улсад байгаль орчны бодлого, үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж, тулгамдсан асуудлаа хэрхэн шийддэгийг танилцуулж, энэ чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгээс бодлогын дэмжлэг авах боломж нээгдэх юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч бөгөөд Цөлжилттэй тэмцэх конвенцын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ибрахим Тио Монгол Улсад бүх талын дэмжлэг үзүүлж, арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллахаар болов.


Ингэснээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэх, дэлхийн болон Зүүн хойд Азийн бүс нутгийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, шар шороон шуурга, хөрсний доройтлын нөлөөллийг бууруулах, ойжуулалт, нөхөн сэргээлт хийх, улмаар Тогтвортой хөгжлийн зорилтуудыг урагшлуулахад хувь нэмрээ оруулах юм.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцдог эмэгтэй энхийг сахиулагчдын олон улсын бага хурлыг таван жил тутамд эх орондоо зохион байгуулж байхаар шийдвэрлэснийг мэдэгдэв.

Энэхүү шийдвэр нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” тогтоолыг хэрэгжүүлэх, олон улсад таниулах, НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаа дахь Монгол Улсын оролцоог өргөжүүлэх ач холбогдолтой юм.

Энэхүү чуулганы үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Дэлхийн түүхэнд “Монголын их амар амгалан” дэг журмыг тогтоож явсан монголчуудын үр сад бид дэлхийн улс орнууд харилцан ойлголцож, хамтран ажиллаж, аливаа зөрчил тэмцлийг энхийн яриа хэлэлцээний замаар, эв зүйгээр зохицуулж чадах аваас цэнхэр дэлхий минь амар амгалан болж, хүн төрөлхтөнд “Дэлхийн амар амгалан” ирэх болно гэдгийг хэлэхийн ялдамд энэхүү энхийн үйлсэд хамтран зүтгэхийг дэлхийн улс түмэнд уриалж байгаагаа илэрхийлсэн юм.





НҮБ-ыг монголчууд бид туулсан нэгэн жарны маань итгэлт нөхөр, туулах олон жарны маань өмөг түшиг хэмээн хардаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Угнаагийн Хүрэлсүх

Ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, “Тэрбум мод” санаачилга

“Тэрбум мод” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЭХЛҮҮЛСНЭЭ ЗАРЛАВ

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх эх орондоо “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн өрнүүлэхээ зарласны дагуу Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар хооронд Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” баримт бичгийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр байгуулав. “Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт” тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Тэрбум мод” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-тай хамтран ажиллах болсон нь олон улсын байгууллагатай хамтрах үндсийг тавьсны зэрэгцээ олон талт хамтын ажиллагааны хүрээнд ажиллах баримт бичиг боллоо.



Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ази, Номхон далайн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /ГНБД/ А.Алисжабантай уулзаж, “Тэрбум мод” хөдөлгөөнийг санхүүжүүлэх чиглэлээр Ази номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссыг Монгол Улсын Сангийн яамтай холбож, хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэв.





Монгол Улс 2002 оноос хойш дэлхийн гурван тив дэх НҮБ-ын энхийг сахиулах 13 ажиллагаанд 20 орчим мянган цэнхэр дуулгатнаа оролцуулаад байна. Энэ нь манай улсын хүн амын тоо болон Зэвсэгт хүчний алба хаагчдын тоотой харьцуулахад дэлхийд дээгүүр ордог үзүүлэлт юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалт 2021

Монгол Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 23 хувь бууруулна

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН ХААНТУЛСЫН ГЛАЗГОУХОТНОО 2021 ОНЫ 11 ДҮГЭЭСАРЫН 1-НЭЭС 2-НЫ ӨДРҮҮДЭД БОЛСОН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДЛААРХ ДЭЛХИЙН УДИРДАГЧДЫН ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО.

Энэ үеэр Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувь хүртэл бууруулах зорилт тавьснаа мэдэгдэв.

Тэрбээр 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж ургуулахын тулд жил бүр Дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас багагүй хэмжээний хөрөнгө зарцуулах болсныг зарлалаа.

Манай улс Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад жил бүр Ерөнхийлөгчийн түвшинд оролцож байгаа нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх дэлхий нийтийн чармайлтад оруулж буй үндэсний хувь нэмрийг танилцуулах, оролцогч талуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлэх, олон талт хамтын ажиллагааны үйл явцад дээд, өндөр түвшинд оролцох давтамжийг хадгалах ач холбогдолтой юм.



Дэлхийн улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилтоо ханган хэрэгжүүлэх, түүн дотроо уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх хүчин чармайлтаа хэрхэвч сулруулж болохгүй, харин ч улам идэвхтэй ажиллах нь чухал байна.



Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалт 2022

2026 онд “COP 27” бага хурал Улаанбаатар хотноо болно

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ АРАБЫН БҮГД НАЙРАМДАХ ЕГИПЕТ УЛСЫН ШАРМ ЭЛЬ-ШЕЙХ ХОТНОО 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 7-8-НЫ ӨДРҮҮДЭД БОЛСОН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДЛААРХ ДЭЛХИЙН УДИРДАГЧДЫН ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ.



United Nations Climate Change



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин бидэнтэй хамтран ажиллаж байгаа дэлхийн улс орнууд, хөгжлийн түншүүд, олон улсын байгууллагуудад гүн талархал илэрхийлэхийн зэрэгцээ Монгол Улс Европын Холбооны “Ойн түншлэл” хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах Ази тивийн анхны улс болж байгааг дуулгахад таатай байна.



Монгол Улсын Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх



Европын Холбоотой “Ойн түншлэл”-ийн хүрээнд нягт хамтран ажиллахаар тохиролцов.

Харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, зоримог шийдвэр, тууштай хичээл зүтгэл уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тавьсан зорилтоо цаг хугацаанд нь амжилттай ханган хэрэгжүүлж, цаашид тогтвортой хөгжлийг цогцлоход онцгой чухал үүрэгтэй.

Уур амьсгалын өөрчлөлт, хүнсний хангамж, аюулгүй байдал, хүний эрүүл мэндийн асуудлыг Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд цогцоор авч үзэх учиртайг Ерөнхийлөгч У.Хүрэлсүх тэмдэглэж, “Тэрбум мод” зэрэг үндэсний хөдөлгөөнийг дэмжин хамтран ажиллаж байгаа улс орнууд, хөгжлийн түншүүд, олон улсын байгууллагуудад талархал илэрхийлэв.

Дээд түвшний уулзалтын үеэр Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Европын Комиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Лайентай уулзаж, харилцаа, хамтын ажиллагаа, ялангуяа ногоон хөгжил, байгаль орчны хамгааллын чиглэлээр санал солилцов.

Талууд “Ойн түншлэлийн тухай Монгол Улс, Европын Холбоо хоорондын Харилцан ойлголцлын Санамжбичиг”-т гарын үсэг зурснаар ойн тогтвортой менежмент, ой хамгаалал, нөхөн сэргээлт, ойн аж ахуйд түшиглэсэн ажлын байрыг олноор бий болгох, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөрөнгө оруулалт татах, цөлжилт, ойн хомсдолтой тэмцэх чиглэлд хамтран ажиллах боломж бүрдэв.

Европын Холбооны “Ойн түншлэл” нь ой модыг нөхөн сэргээх, зохистой ашиглалт, хамгаалалтыг дэмжих, ойг түшиглэсэн эдийн засгийн салбар, орлогын эх үүсвэр бий болгоход чиглэж байна.

Монгол Улс Европын Холбоотой уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, өөрчлөлтийг сааруулах чиглэлээр ойн нөөцийг урт хугацаанд тогтвортой ашиглахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог шинэчлэн боловсруулж, сайн засаглал, тогтвортой менежментийг дэмжих чиглэлээр хамтран ажиллана.

Түүнчлэн АНУ, Европын Холбооны “Дэлхийн метаны амлалт” санаачилга, Испанийн Хаант Улс, Сенегал Улс, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын хамтран санаачилсан “Ган гачигтай тэмцэх олон улсын эвсэл”-д нэгдэн оров.



Монгол Улсыг дэлхийд дахинд таниулсан айлчлал

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш Монгол Улсад айлчлав



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР
НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА АНТОНИО
ГУТЕРРЕШ 2022 ОНЫ 8 ДУГААР
САРЫН 8-11-НИЙ ӨДРҮҮДЭД
МОНГОЛ УЛСАД АЛБАН ЁСНЫ
АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Айлчлалын үеэр талууд Зүүн хойд Азийн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиров.

Ерөнхий нарийн бичгийн дарга Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Нэн буурай хөгжилтэй, далайд гарцгүй хөгжиж буй болон арлын жижиг орнуудын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгч Рабаб Фатимаг Монгол Улсад айлчлуулах, “Тэрбум мод” санаачилга нь цөлжилт, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, биологийн олон янз байдлыг хамгаалахад үр нөлөөтэй болохыг тэмдэглэж, энэ чиглэлээр хамтран ажиллахаа илэрхийлэв.



Цөлжилтийг сааруулах хамгийн үр ашигтай арга бол мод тарих юм. Монголчууд бид мод тарих, ном туурвих, үр хүүхэд төрүүлж өсгөхийг дээд гурван буян гэж ярьдаг. Тиймээс дэлхий нийтийн өмнө тулгараад буй уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахын тулд 2030 он гэхэд Монгол Улсад тэрбумаар тоологдох хэмжээний мод тарьж ургуулах хөдөлгөөн өрнүүлж эхлээд байна.

Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн “Энхийг сахиулагчдын төгөл”-д мод тарив.

Энэ нь дэлхий дахинд тулгамдаад буй уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх, ой усны нөөцийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр Монгол Улсын гаргаж буй хүчин чармайлт, Монгол Улсын энхийг сахиулах ажиллагаанд оруулж буй хувь нэмрийг олон улсад таниулсан чухал арга хэмжээ болов.

Дэлхий дахинд энх тайван амар амгалан байдал улам бүр хомсдож буй энэ үед энх тайвны бэлгэ тэмдэг болсон Монгол Улсад айлчилж байгаадаа баяртай байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш





**Дэлхий дахинд
энх тайван, амар
амгалан байдал
улам бүр хомсдож
буй энэ үед энх
тайвны бэлгэ тэмдэг
болсон Монгол Улсад
айлчилж байгаадаа
баяртай байна.**



*НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга
Антонио Гутерреш.*

Цөмийн зэвсгийг хураах, үл дэлгэрүүлэх, Солонгосын хойгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр Монгол Улсын хувь нэмрийг өндрөөр үнэлэв



ЦӨМИЙН ЗЭВСЭГГҮЙ БҮС-30 ЖИЛ

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийн айлчлал нь “Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс” хэмээн зарласны 30 жилийн ойтой давхцаж байгаагаараа онцлог байв.

Мөн Монгол Улс, НҮБ-ын харилцаа, хамтын ажиллагааг урагшлуулах, Монгол Улсын Зүүн хойд Азийн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг таниулж, нэр хүндийг өсгөхөд чухал ач холбогдолтой болов.

Дэлхий дахинаа геополитикийн сорилтууд тулгарч буй энэ цаг үед НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш манай улсад хийсэн айлчлалаа “Цөмийн зэвсэггүй нутагт хийж буй айлчлал” хэмээн онцолсон нь үүний нэг илэрхийлэл юм.



Олон улсын эмэгтэй энхийг сахиулагчид Монгол Улсад чуулав



Монгол Улс 2027 он гэхэд цэргийн багийн бие бүрэлдэхүүний 15, бие даан үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний 25 хувийг эмэгтэй цэргийн алба хаагчаар бүрдүүлж, НҮБ-аас тавьсан зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн ивээл дор 2022 оны 6 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал” олон улсын энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн хурлыг бүс нутагтаа анх удаа зохион байгуулав.

Энэ нь манай улсын энхийг сахиулах ажиллагааны оролцоог шинэ шатанд гаргаж, олон талт, идэвхтэй оролцоог бий болгоход чухал ач холбогдолтой байв.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Энхийн ажиллагаа хариуцсан орлогч Жан Пьер Лакруа “Монгол Улс энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн асуудалд анхаарч байгаа нь НҮБ-ын жендэрийн тэгш байдлыг хангах зорилго, зорилтуудыг тууштай хэрэгжүүлж байгаагийн нотолгоо” гэж үздэгээ онцлов.



**Бусад улс орон Монгол
Улсын санаачилгыг
дагаж, энхийг сахиулах
үйлсэд эмэгтэйчүүдийн
үүрэг, оролцоог
нэмэгдүүлэх чиглэлээр
ажиллана гэдэгт итгэж
байна.**



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Энхийн ажиллагаа хариуцсан орлогч Жан Пьер Лакруа



2022.06.16–2022.06.19

Жан Пьер Лакруа

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Энхийн ажиллагаа хариуцсан орлогч

Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Энхийн ажиллагаа хариуцсан орлогч Жан Пьер Лакруаг 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч уулзав.

Жан Пьер Лакруа Улаанбаатар хотноо 2022 оны 6 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд болсон “НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй цэргийн алба хаагчийн оролцоо” олон улсын бага хуралд оролцов.

Уг айлчлал Энхийг сахиулах ажиллагааны хүрээнд Монгол, НҮБ-ын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” тогтоолын хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой болов.

Такеши Касай

*Дэлхийн Эрүүл Мэндийн
Байгууллагын Номхон Далайн
баруун бүсийн захирал*

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ
ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН НОМХОН
ДАЛАЙН БАРУУН БҮСИЙН
ЗАХИРАЛ ДР.Т.КАСАЙГ 2022
ОНЫ 6 ДУГААР САРЫН
14-НИЙ ӨДӨР ХҮЛЭЭН
АВЧ УУЛЗАЖ, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ АСУУДЛААР
САНАЛ СОЛИЛЦОВ.



2022.06.23-2022.06.27



Ерөнхийлөгч Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, хүнсний хангамж, аюулгүй байдал, хүний эрүүл мэндийн асуудлыг цогцоор авч үзэх учиртайг тэмдэглэж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн өрнүүлэн, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлж буйг танилцуулав.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Номхон далайн баруун бүсийн захирал Др. Т.Касай Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй үндэсний хөдөлгөөнүүд ДЭМБ-ын зорилтуудтай нягт уялдаж буйг тэмдэглээд Монгол Улсад өрнөж буй үндэсний гурван хөдөлгөөн нь бүс нутгийн болон гишүүн орнуудад туршлага болохуйц ажил болж байгааг тэмдэглэв.

Боловсрол, шинжлэх ухаан, соёл



Дэлхийн цэнгэг усны нөөцийн 2 хувь, Монгол Улсын цэнгэг усны нөөцийн 70 гаруй хувийг дангаар бүрдүүлдэг Хөвсгөл нуурыг Дэлхийн шим мандлын сүлжээнд бүртгэсэнд Монголын ард түмний нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлэв.



Хөвсгөл нуурыг ЮНЕСКО-ийн хамгаалалтад оруулав

МОНГОЛ УЛСАД 2022 ОНЫ 7 ДУГААР САРЫН 10-14-НИЙ ӨДРҮҮДЭД АЛБАН ЁСООР АЙЛЧИЛСАН НҮБ-ЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА (ЮНЕСКО)-ЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ ОДРИ АЗУЛЕЙ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХЭД БАРААЛХАВ.

Бараалхалтын үеэр Одри Азулей Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд ЮНЕСКО-ийн Дэлхийн шим мандлын нөөц газруудын сүлжээнд Хөвсгөл нуур байгалийн цогцолборт газрыг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр бүртгэсэн гэрчилгээг гардуулав.

Айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, ЮНЕСКО-ийн хооронд 2022-2029 онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны тухай Харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулсан. Түүнчлэн боловсролын салбар дахь цахим шилжилт, Монгол Улсад геопарк байгуулах талаар санал солилцож, мэдээлэл, харилцаа холбоо, соёл, байгалийн шинжлэх ухаан зэрэг салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцсон. Айлчлалын мөрөөр Хүннү рок чиглэлээр бүтээл туурвидаг “The NU” хамтлаг “ЮНЕСКО”-ийн энх тайвны төлөөх уран бүтээлч” цол хүртсэн.

Уг айлчлал нь Монгол Улс ЮНЕСКО-ийн гишүүнээр элссэний 60 жилийн ойн хүрээнд хэрэгжсэнээрээ онцлог байв. Энэхүү айлчлал харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, Монгол Улс ЮНЕСКО-ийн үйл ажиллагаанд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх, тус байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийг эрчимжүүлэх, манай улсын мэргэжилтнүүдийг шаардлагатай арга зүй, мэргэжлийн туршлага, дадлага эзэмшүүлэх сургалтад хамруулахад чухал ач холбогдолтой байв.





SHANXAY HAMKORLIK TASHKILOTIGA A'ZO DAVLATLAR
RAHBARLARI KENGASHI YIG'ILISHI
2022-yil 15-16 sentabr, Samarqand

ЗАСЕДАНИЕ СОВЕТА ГЛАВ ГОСУДАРСТВ-ЧЛЕНОВ
ШАНХАЙСКОЙ ОРГАНИЗАЦИИ СОТРУДНИЧЕСТВА
15-16 сентября 2022 года, Самарканд



БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

上海合作组织成员国元首理事会会议

(2022年9月15-16日, 撒马尔罕)

MEETING OF THE COUNCIL OF HEADS
OF THE SHANGHAI COOPERATION ORGANIZATION MEMBER STATES
15-16 September 2022, Samarkand

Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцоно. Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцоно.

*Монгол Улсын Гадаад бодлогын
үзэл баримтлалаас*



ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан 2021, 2022

Монгол Улс ШХАБ-д ажиглагч статусаа хадгална



Бүгд Найрамдах Тажикистан Улсын нийслэл Душанбе хотноо 2021 оны 9 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд болсон ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх цахимаар, 2022 оны 9 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Узбекистан Улсын Самарканд хотноо болсон хуралд биечлэн оролцов.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улс ШХАБ-ын үйл ажиллагаанд эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, хүмүүнлэгийн чиглэлээр идэвхтэй оролцох сонирхолтойг илэрхийлж, цөлжилттэй тэмцэх, элсний нүүдлээс хамгаалах, шар шороон шуурганы нөлөөг бууруулах чиглэлээр бүс нутгийн хэмжээнд нягт хамтран ажиллахын төлөө байгаагаа мэдэгдэв.




Монгол Улсын Ерөнхийлөгч ШХАБ-ын гишүүн орнуудтай худалдаа, хөрөнгө оруулалт, эрчим хүч, тээвэр ложистик, байгаль орчин, аялал жуулчлал, мэдээллийн технологи, хөдөө аж ахуй, хүнсний хангамж-аюулгүй байдал, хүмүүнлэгийн салбарт хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлж, улс хоорондын болон бүс нутгийн эдийн засгийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх, бодит ажил хэрэг болгох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

合作组织成员国元首理事会会议

(2022年9月15-16日, 撒马尔罕)

MEETING OF THE COUNCIL OF HEADS
OF THE COOPERATION ORGANIZATION MEMBER STATES
15-16 September 2022, Samarkand



Түүнчлэн энэ удаагийн ШХАБ-ын хуралдааны үеэр хамтын ажиллагааны талаар болон гишүүн, ажиглагч орнуудын бодлого, үйл ажиллагааны тухай мэдээлэл авч, Монгол Улс ШХАБ-ын гишүүнчлэлийн асуудалтай холбогдуулан ажиглагчийн байр сууриа үргэлжлүүлэн хадгалахаа Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх нотлов.

Мөн Ази, Европыг холбосон газар зүйн байршлын давуу талаа ашиглан худалдаа, тээвэр ложистикийн сүлжээ, ачаа тээврийн урсгал, үйлчилгээний зангилаа болсон “Транзит

Монгол” болох зорилтыг хэрэгжүүлэх болон “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хамтран ажиллахыг урив.

“Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-г тусгасан төмөр замын төв коридорыг шинэчлэх, зүүн болон баруун коридор шинээр барих, гурван улсыг холбосон хурдны автозам, хийн хоолой барих зэрэг стратегийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ач холбогдолтой байв.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын уулзалт



Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нар уулзав

ЭНЭ УДААГИЙН ШХАБ-ЫН ХУРАЛДААНЫ ҮЕЭР МОНГОЛ УЛС, ОХУ, БНХАУ-ЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН НАРЫН VI УУЛЗАЛТ 2022 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР БОЛОВ.

“Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэх, орос, хятадын талтай Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан байгалийн хийн хоолой барих, мөн эрчим хүчний төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг асуудлаар санал солилцов.

Түүнчлэн “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т тусгасан гурван улсыг холбосон төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх, Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эхлэхээр тохиролцож, гурван улсын хооронд авто тээврийг хөгжүүлэх, Азийн автозамын сүлжээгээр гурван улсын хооронд тээврийг нэмэгдүүлэх, хил дамнан аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар ярилцав.

Байгалийн хий нийлүүлэх хоолой барих төсөл нь гурван улсын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой болохыг талууд онцолж, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төсөл хариуцсан холбогдох аж ахуйн нэгжүүдийн уялдаа холбоог хангах нь чухал гэдэгт санал нэгдэв.

Төрийн тэргүүн нарын ээлжит уулзалтын дүнд “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хугацааг таван жилээр сунгасныг зарлав.

Мөн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хүрээнд “Эрдэнэбүрэнгийн УЦС”, “Эгийн голын УЦС” байгуулах төслүүдэд хөрш орнуудтай идэвхтэй хамтран ажиллах саналаа илэрхийлж, энэ чиглэлээр шинжээчдийн түвшинд хамтран ажиллахаар тохиров.




Стратегийн түнш, хөрш орнуудын харилцааг өргөжүүлэн бэхжүүлэх, улс төр, эдийн засгийн гурван талт хамтын ажиллагааны цар хүрээг тэлэх зорилго бүхий энэхүү уулзалтыг 2014 оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулж байна.



Монгол Улсын газар зүйн байршлын онцлогт тулгуурлан олон улсын транзит тээврийг хөгжүүлэх, энэ хүрээнд гурван улсын эдийн засгийн коридорын хөтөлбөрт тусгасан төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нь чухал.



Монгол Улсын Ерөнхийлөгч
Угнаагийн Хурэлсүх







ХӨРШ ОРНУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана.

*Монгол Улсын Гадаад бодлогын
үзэл баримтлалаас*

3

Харилцаа, хамтын ажиллагааны шинэ үе эхэллээ

Оросын Холбооны Улсад төрийн айлчлал хийв



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
У.ХҮРЭЛСҮХ 2021 ОНЫ 12 ДУГААР
САРЫН 15-17-НЫ ӨДРҮҮДЭД
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСАД
ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Энэхүү айлчлал Монгол, Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хүрээнд хэрэгжсэнээрээ онцлог байсан.

Талууд түүхт 100 жилийн ойг 2021 оны туршид ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлснийг дүгнэж, сүүлийн жилүүдэд хоёр улсын хооронд хуримтлагдаад байсан худалдаа, эдийн засгийн асуудлуудыг шуурхай шийдвэрлэн, харилцааны цаашдын хөгжлийн талаарх дунд хугацааны хөтөлбөр (замын зураглал)-ийг боловсруулахаар тохиролцов.



Айлчлалаар улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах, цэрэг-техник, хөдөө аж ахуй, эрчим хүч, худалдаа, эдийн засаг, боловсрол, байгаль орчныг хамгаалах салбарын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэх, түлш, газрын тосны бүтээгдэхүүнийг тасралтгүй, тогтвортой нийлүүлэх, ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий нийлүүлэх хоолойг Монгол Улсын

нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийг дэмжих зэрэг асуудлыг хэлэлцэв.

“Транзит Монгол” үндэсний хөтөлбөрийг ОХУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Их Евразийн түншлэл” санаачилгатай уялдуулан хэрэгжүүлэх боломжтойг онцлов.



“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дүрмийн санг нэмэгдүүлэх, дүрмийн санд оросын талаас оруулах хувь хэмжээтэй дүйцэх мөнгөн дүнгийн хэмжээгээр ОХУ-д үйлдвэрлэсэн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх саналыг оросын тал дэмжлээ. Чингэснээр төмөр замын нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх боломж бүрдэв.

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн өмнө тулгамдаад байсан МОН-П1, МОН-П2 зээлийн өрийн үлдэгдэл, тээвэрлэлтийн тарифын бодлого, газрын эзэмшил зэрэг асуудлаар санал солилцож, зарим тохиролцоонд хүрсэн. Эдгээр нь тус нийгэмлэгийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх, хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болсон.




Айлчлалын үеэр хилийн боомт болон Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд холбогдох сайд нар гарын үсэг зурав.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр хилийн боомтын төрөл, горим, зэрэглэлийг тодорхой болгох, зарим хилийн боомтыг олон улсын зэрэглэлд шилжүүлэх, хэлэлцээр байгуулснаас хойш нээн ажиллуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй зарим боомтыг хэлэлцээрийн хавсралтаас хасах зэрэг зохицуулалт хийв.

Албан ёсны айлчлалаар хоёр улсын харилцааны шинэ үеийг эхлүүлж, томоохон төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн харилцааг идэвхжүүлэхээр тохиролцов.

Айлчлалын дүнгээр ирээдүйн хамтын ажиллагааг чиглүүлэх хэтийн төлөв бүхий улс төрийн баримт бичиг болох Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн Хамтарсан тунхаглал гаргасан.





2022.07.05

Сергей Викторович Лавров

ОХУ-ын Гадаад хэргийн сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХЭД 7 ДУГААР САРЫН 5-НЫ ӨДӨР ОХУ-ЫН ГАДААД ХЭРГИЙН САЙД СЕРГЕЙ ВИКТОРОВИЧ ЛАВРОВ БАРААЛХАВ.

Энэ удаагийн айлчлалаар олон улсын харилцааны амаргүй нөхцөлд тус тусын байр сууриа танилцуулж, харилцан ойлголцолд хүрэв.

А-92 шатахууныг 2022 оныг дуустал тогтсон үнээр буюу нэг тонн бензинийг 830 ам.доллаар худалдан авах тохиролцоонд хүрэв.

Монголын тал Эгийн голын цахилгаан станцын төслийг хамтран хэрэгжүүлэх санал тавьж, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дүрмийн санг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэлийг эхлүүлэх тохиролцоонд хүрэв.


ОХУ-ын Гадаад хэргийн сайдын айлчлал олон улсын харилцааны шинэ нөхцөл байдалд уламжлалт сайн хөршийн найрсаг харилцааг хадгалах, харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх, Иж бүрэн стратегийн түншлэлийг хэвийн үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой болов.



Монгол Улс уул уурхайн экспортын хэмжээг үлэмж нэмэгдүүлнэ

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад төрийн айлчлал хийв





Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2022 оны 11 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Ши Жиньпиний урилгаар тус улсад төрийн айлчлал хийв.

Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн БНХАУ-д Ерөнхийлөгчийн хувиар хийсэн анхны айлчлал бөгөөд Хятадын Коммунист Намын XX Их хурлын дараа болсноороо онцлог байлаа.

Монгол Улс, БНХАУ хоорондын улс төрийн харилцааг бэхжүүлэх, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, худалдааны хэмжээг 20 тэрбум ам.долларт хүргэх, боомтын нэвтрүүлэх хүчин чадал, ачаа тээврийн хэмжээ болон экспортыг нэмэгдүүлэх, боомтуудыг төмөр замаар холбох ажлыг эрчимжүүлэх, эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй төслүүдийн явц, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах, боловсрол, хүмүүнлэгийн харилцааг дэмжих зэрэг асуудлаар санал солилцов.

Мөн Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, “Эдийн засгийн коридор”-ын бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхээр ярилцав.

2022 он Монгол Улс, БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагааны түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн он болов.



Хилийн боомтуудаа төмөр замаар холбох ажил эрчимжлээ



Худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, дэд бүтэц зэрэг салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 16 баримт бичигт гарын үсэг зурав.

АЙЛЧЛАЛЫН ҮР ДҮН:

- Нүүрсний худалдааг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгжүүд хооронд нүүрс худалдаалах урт хугацааны гэрээ байгуулах,
- Гацуунсухайт - Ганцмод, Шивээхүрэн - Сэхээ, Бичигт - Зүүнхатавч зэрэг боомтыг төмөр замаар холбох бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, Ханги - Мандал боомтыг төмөр замаар холбох,
- Уламжлалт болон сэргээгдэх эрчим хүчний хамтын ажиллагааг эрчимжүүлэх,
- “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээ”-ний хугацааг сунгах,
- БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд Монгол Улсад “Үндэсний урлагийн их театр”, “Ерөнхийлөгчийн нэрэмжит хүүхэд, залуучуудын спорт сургалтын төв” байгуулах,
- Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, шороон шуурга, цөлжилттэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллаж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Цөлжилттэй тэмцэх судалгааны төв байгуулах,
- Соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологи, аялал жуулчлал зэрэг салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх,
- Хүмүүнлэгийн харилцаа, ялангуяа хүүхэд, залуучуудын солилцоог эрчимжүүлэх, энэ хүрээнд “Ерөнхийлөгчийн илгээлт - 2100” тэтгэлэгт хөтөлбөрийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах,



19 заалт бүхий Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан мэдэгдэл гаргав.

Хөрш орнуудын үлгэр жишээ харилцааг нотолсон айлчлал

- Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, ОХУ-аас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан БНХАУ руу байгалийн хийн хоолой барих төслийг хэрэгжүүлэх гурван талын Ажлын хэсэг байгуулах,
- Гурван улсыг холбосон төмөр замын төв коридорыг шинэчлэх ТЭЗҮ-ийн судалгааг эхлүүлэх,
- Алтанбулаг - Замын-Үүд чиглэлийн олон улсын транзит хурдны зам барих зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар санал нэгдэв.

Гурван улсын “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй эдгээр төсөл нь Монгол Улсын эдийн засаг, тээвэр логистикийн хөгжилд чухал ач холбогдолтой төдийгүй бүс нутгийн авто зам, төмөр зам, дэд бүтцийн хөгжилд чухал хувь нэмэр оруулна.



БНХАУ-тай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг бөгөөд хоёр улсын хамтын ажиллагааг тус тусын хөгжлийн бодлого, зорилтуудтай уялдуулан хөгжүүлэх нь чухал юм.





2022.08.07–2022.08.08

Ван И

*БНХАУ-ын Төрийн
Зөвлөлийн гишүүн бөгөөд
Гадаад хэргийн сайд*

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
У.ХҮРЭЛСҮХЭД БНХАУ-
ЫН ТӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН, ГАДААД ХЭРГИЙН
САЙД ВАН И 2022 ОНЫ
8 ДУГААР САРЫН 8-НЫ
ӨДӨР БАРААЛХАВ.

Монгол, Хятадын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа амжилттай хөгжиж байгааг Ерөнхийлөгч онцолж, олон улсын амаргүй нөхцөл байдал, цар тахлын үед ч харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр бэхжүүлэн, ойр дотно хамтарч ажиллах нь зүйтэйг тэмдэглэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч мөн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх, энэ хүрээнд дунд хугацааны стратеги төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахын төлөө байгаагаа илэрхийлэв.

Гадаад хэргийн сайд Ван И хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг бүх салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө байгаагаа тэмдэглэж, хамтран ажиллахаа нотлов.

Уулзалтын үеэр тээвэр ложистик, уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа, Монгол Улс, БНХАУ, ОХУ хооронд эдийн засгийн коридор байгуулах болон олон улс, бүс нутгийн асуудлаар санал солилцов.

Тухайлбал, Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, Замын-Үүд-Эрээн боомтын төмөр замын галт тэрэг солилцооны хэмжээг нэмэгдүүлэх, хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, боомтуудыг дэлхийн стандартад нийцсэн жишиг боомт болгох талаар ярилцав.



Ханги-Мандал боомтыг төмөр замаар холбох хүсэлтийг хятадын тал анхааралдаа авч, дотоодын холбогдох байгууллагатайгаа ярилцахаа илэрхийлэв.

Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станцын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, БНХАУ-д суралцаж буй оюутнуудыг үргэлжлүүлэн танхимаар хичээллүүлэхээр тохиролцож, иргэдийн харилцан зорчих хөдөлгөөнийг хялбаршуулж сэргээхээр болов.

Хоёр улсын төрийн тэргүүн нарын тохиролцсоны дагуу цөлжилт, шороон шуургатай тэмцэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр болов.




2022.09.10–2022.09.11

Ли Жанышу

*БНХАУ-ын Бүх Хятадын Ардын
Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын
Хороо /БХАТИХ/-ны дарга*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
У.ХҮРЭЛСҮХЭД БНХАУ-ЫН
БҮХ ХЯТАДЫН АРДЫН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРОО /БХАТИХ/-НЫ
ДАРГА ЛИ ЖАНЬШУ 2022 ОНЫ
9 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР
БАРААЛХАВ.




Хоёр орны харилцаа нь бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, язгуур эрх ашгийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш, харилцан ашигтай байх, тус тусын сонгосон хөгжлийн замыг харилцан хүндэтгэх Иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээний суурь зарчим болон даян дэлхийн аюулгүй байдлын санаачилгад суурилж байна.

Айлчлалын үеэр Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд өндөр ач холбогдол өгч, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хий нийлүүлэх хоолой барих, гурван улсыг холбосон Алтанбулаг-Замын-Үүд чиглэлийн хурдны автозам барих зэрэг төслийг урагшлуулах чиглэлээр санал солилцов.

Энэ удаагийн айлчлал харилцан итгэлцлийг бэхжүүлж, бүх түвшний харилцааг урагшлуулан хөгжүүлэх, хууль тогтоох байгууллагууд хоорондын тогтсон харилцааг улам бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.





ГУРАВДАГЧ ХӨРШИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын улс төрийн гадаад бодлогын нэг хэсэг нь “АНУ, Япон, Европын Холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” гэж заасан. Монгол Улс уг бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж байна.

Япон Улстай энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэлийг хөгжүүлнэ

Япон Улсад төрийн айлчлал хийв



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НӨӨС 12 ДУГААР САРЫН 2-НЫ ӨДРҮҮДЭД ЯПОН УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Монгол Улсын төрийн тэргүүний түвшинд 2010 оноос хойш 12 жилийн дараа Япон Улсад хийсэн энэ айлчлал нь хоёр улсын 50 жилийн харилцаа хамтын ажиллагааг дүгнэж, ирэх 50 жилд хөгжүүлэх хэтийн төлөв, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой болов.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Япон Улсын Ерөнхий сайд Ф.Кишида нар Монгол Улс, Япон Улсын “Стратегийн түншлэл”-ийн харилцааны түвшнийг ахиулан “Энх тайван,

хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл”-ийг хөгжүүлэхэд чиглэсэн Хамтарсан мэдэгдэл гаргав.

Энэ хүрээнд Монгол, Японы Дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл”-ийн 10 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр байгуулж, 2022-2031 онд Япон Улстай хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зорилт, чиг хандлагыг тодорхойлов.


Монгол Улсын
Ерөнхийлөгч
У.Хүрэлсүх, гэргий
Л.Болорцэцэгийн
хамт Япон Улсын Цог
Жавхлантай Эзэн Хаан
Нарүхито, Эрхэм Дээд
Хатан Масако нарт
бараалхав.



АЙЛЧЛАЛЫН ҮР ДҮН:

- Япон Улсын Засгийн газраас “Монгол Улсын эрчим хүчний хангамжийг сайжруулах төсөл”-ийг буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр тохирч, “Дарханы 10мвт нарны цахилгаан станц”-ыг түшиглэн бага чадлын батарейн цэнэг хураагуур суурилуулах,
- “Устөрөгчийн үйлдвэрлэл ба дагалдах бүтээгдэхүүн боловсруулах” чиглэлээр хамтрах,
- “Төв аймгийн Хөшигийн хөндий дэх шинэ хот болон эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийг Япон Улсын техникийн хамтын ажиллагааны хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх,
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хамтын ажиллагааг эрчимжүүлэх, энэ хүрээнд Японы тал “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж 50 мянган мод тарьж, ойжуулах,
- Монголын 20 мянган хүүхэд, залууст байгаль орчин, цөлжилт, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр танин мэдэхүйн сургалт зохион байгуулж, сургагч багш нар бэлтгэх,
- Монгол, Японы оюутан, залуучуудын солилцооны чуулга уулзалтыг 2023 онд Монгол Улсад зохион байгуулахаар болов.





Дипломат харилцаа
тогтоосны 50 жилийн ойн
хаалтын арга хэмжээ болгон
Монгол Улсын филармонийн
“Морин хуурын чуулга”
Японы “NHK” их танхимд
анх удаа тоглолтоо
толилуулж, соёл, урлагийн
хамтын ажиллагааг
бэхжүүлэв.

28 жилийн дараа биелсэн амлалт

//



Элгэмсэл,
дотносол
үлдээсэн
тэртээх
1994 он

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой 2022 онд тохиосон билээ. Энэ ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2022 оны 10 дугаар сарын 29-нөөс 11 дүгээр сарын 02-нд Япон Улсад төрийн айлчлал хийв. Монголын удирдагчид Япон Улсыг албан ёсны гуравдагч хөршөө хэмээн үзэж, хоёр улсын харилцаанд онцгой ач холбогдол өгч ирсэн. Улс орны дипломат харилцаа чухамхүү ард түмэн хоорондын харилцаанд суурилж хөгжинэ хэмээн Ерөнхийлөгч У.Хүрэлсүх үздэг бөгөөд энэ итгэл үнэмшил нь одоогоос 28 жилийн тэртээ Японы хойд нутагт фермерийн аж ахуй эрхлэгч жирийн нэгэн гэр бүлтэй өнгөрүүлсэн халуун дулаан дурсамжаас эхтэй юм.

Тэртээ 1994 онд Такамүра Митошигийн гэр бүл Японы Засгийн газрын залуус солилцооны хөтөлбөрийн хүрээнд Монголоос ирсэн нэгэн залууг гэртээ хүлээн авчээ. Хэдийгээр хэл нэвтрэлцэхэд бэрхшээлтэй байсан ч түүний гэр бүл хожмоо их үйлсийг бүтээх 26 настай залуутай долоо хоног орчим ихэд дурсамжтай, хөгжилтэй өнгөрүүлжээ. Гэрийн эзэн ноён Такамүра энэ тухай "Homestays" хөтөлбөрийн залуус зочилсон айлдаа ихэвчлэн нэгээс хоёр хоног л байдаг байсан. Харин тэр илүү олон хоногийг өнгөрүүлсэн учир бид илүү дотносож нэг гэр бүл шиг болсон" хэмээн өдгөө дурсаж байна.

Монгол Улсын ирээдүйн Ерөнхийлөгч ноён Такамүрагийн хоёр дахь охин Томомитай хамгийн ойр дотно нөхөрлөж, түүнийг өхөөрдөн яг л өөрийн охин мэт халамжилж анхаарал тавьдаг байжээ. "Охинтой нь нас чацуу байсан болохоор тэр намайг үргэлж өхөөрддөг, онцгойлж үздэг байв. Бид дандаа хамт тоглодог байсныг санаж байна" гэж Тономи ярилаа. Тэд байнга хамтдаа байж, нутгийн баяр ёслолд очсон ч, далайн эрэг орсон ч үргэлж цуг цагийг өнгөрөөдөг байжээ. "Бид бие биетэйгээ зөнгөөрөө л ойлголцдог байлаа. Тиймээс хүмүүс сэтгэлээрээ дамжуулан харилцаж чаддаг юм байна гэдгийг ойлгосон. Тэр үед бид сэтгэл зүрхээрээ ярилцдаг байв". Энэ бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэртээ олон жилийн өмнө Японд өнгөрүүлсэн өдрүүдээ дурссан сэтгэлийн үг.

"Үргэлж хамт байж, анхаарал тавьдаг байсан болохоор цөөхөн хоног нөхөрлөсөн ч би түүнд үнэхээр дассан байв. Магадгүй хүүхдийн зан байх. Тиймээс түүнийг буцах болоход нь уйлж, маш их гунигласан. Манай гэр бүл Засгийн газрын хөтөлбөрөөр олон хүнийг хүлээж авч байсан ч ганцхан Хүрлээг буцах болоход л би уйлж билээ". Тономи хүүхэд ахуй насныхаа гэрэлт өдрүүдийг ийнхүү дурсав. У.Хүрэлсүх нутаг буцахынхаа өмнө Тономи болон түүний гэр бүлийг эх орондоо урьж, хэзээ нэг өдөр Монголд найрсаг дотноор уулзана гэдгээ амлажээ.



Монгол Улс, Улаанбаатар хот 28 жилийн дараа

Тухайн үед Монгол Улс социалист систем бүхий нийгмээс зах зээлийн эдийн засаг руу дөнгөж шилжээд байсан юм. Тиймээс нийгэм, эдийн засгийн хувьд томоохон өөрчлөлтүүд гарч, хүмүүсийн амьдралын хэв маяг ч ихээхэн өөрчлөгдөж байлаа. Ирээдүйд улстөрч болох хүсэл мөрөөдөл тээсэн залуугийн хувьд Дэлхийн II дайны дараах хүнд хэцүү байдлаас эдийн засгийн хүчирхэг гүрэн болж чадсан Япон Улсын туршлагаас эх оронд нь үлгэр дуурайлал авах зүйл их байгааг мэдэрч ойлгож авчээ.

Японы ард түмний хөдөлмөрч, бие биенээ хүндэлж халамжилдаг зан чанар нь өнөөгийн энэ улсын хөгжил дэвшлийг бүтээсэн гэж үздэг гэдгээ Ерөнхийлөгч У.Хүрэлсүх илэрхийлээд, энэ улсад үзэж харсан ажил, амьдралын хэв маяг миний улс төрийн замналд чухал нөлөө үзүүлсэн хэмээв.

Монголын эдийн засаг 1990-ээд оны дунд үеэс тогтворжиж, У.Хүрэлсүх улстөрч болох мөрөөдлөө биелүүлж, улс орныхоо сайн сайхны төлөө хүчин зүтгэх болов. Хожим нь тэрбээр Монгол Улсын Ерөнхий сайд болж, 2021 онд Ерөнхийлөгчөөр сонгогдсон юм.

Дурсамж дүүрэн өнгөрүүлсэн 7 хоног Монгол Улс, Улаанбаатар хот 28 жилийн дараа

2020 онд ноён Такамүрагийн гэрт нэгэн захидал ирснийг задлан уншвал "Миний бие Та бүхнийг Монгол Улсад айлчлан ирж, манай гэрт зочлохыг урьж байна" хэмээн бичсэн байлаа. Захидлыг тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайдаас илгээжээ.

"Би захидлыг уншаад ихэд гайхсан, бас их баярласан. Гэр бүлийнхэн маань ч энэ баярт мэдээг сонсоод бүгд маш их баяр хөөр болсон" гэж ноён Такамүра сэтгэгдлээ хуваалцсан юм.

Гэвч тэр үе бол дэлхий нийтийг коронавирусын цар тахлын аюул нөмөрсөн, олон улс орон хилээ хаасан үе таарав. Тиймээс ноён Такамүрагийн гэр бүлийнхэн 2022 оны долоодугаар сард сая Монголыг зорив. Ингээд өөрсдийг нь урьсан Ерөнхийлөгчийн өргөөнд 28 жилийн дараа дотны танилтайгаа баяр хөөр дүүрэн уулзжээ.

"Олон жилийн дараа түүнийг хараад сэтгэл догдолж, баярласандаа уйлчихсан. Түүний инээмсэглэл огтхон ч өөрчлөгдөөгүй байсан учраас Хүрлээг шууд л таньсан. Тэрбээр амласан зүйлээ санаж, бүр түүндээ хүрсэн нь намайг их гайхшруулсан. Энэ тийм ч амар зүйл биш, тиймээс л чин сэтгэлээсэ баярлаад байсан" гэж Томоми олон жилийн хүлээлтийн дараах сэтгэл догдлуулсан тэрхүү уулзалтын уур амьсгалын талаар яриу.

Японы хойд нутгийн нэгэн жижиг ферм дээр өгсөн амлалт ийнхүү биеллээ олсон юм. Энэ бол жирийн нэгэн Монгол хүний гэр бүлийн зочломтгой зан Монгол, Японы харилцаанд үргэлжид урган дэлгэрэх үрийг тарьсан гайхамшигтай, бахархалтай түүх юм. Түүх цаашид улам баяжин үргэлжлэх нь дамжиггүй.

2022 он



Хаяаши Ёшимаса

*Япон Улсын Гадаад
хэргийн сайд*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
У.ХҮРЭЛСҮХЭД ЯПОН УЛСЫН ГАДААД
ХЭРГИЙН САЙД ХАЯАШИ ЁШИМАСА
2022 ОНЫ 5 ДУГААР САРЫН 2-НД
БАРААЛХАВ.

Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд хэрэгжсэн энэхүү айлчлалаар талууд улс төр, нийгэм, эдийн засгийн байдал, гадаад бодлогын талаар харилцан ярилцаж, дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээний талаар санал солилцов.

Тухайлбал, Япон Улсын Цог Жавхлант Эзэн Хааныг Монгол Улсад айлчлуулах, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Япон Улсад хийх төрийн айлчлалыг зохион байгуулах талаар ярилцав.

Талууд Монгол, Японы Стратегийн түншлэлийг 2017-2021 онд хөгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж, 2022-2026 онд хэрэгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд хийх ажлаа тохиролцов.

Монголын тал “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан эдийн засгийн тэргүүлэх салбар, чиглэлд Японы дэвшилтэт технологи, ноу-хау, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг тэлэх төсөл, хөтөлбөр, үүн дотор Хөшигийн хөндийд эдийн засгийн чөлөөт бүс, шинэ дагуул хот байгуулах, нүүрснээс устөрөгч гарган авч устөрөгчийн цахилгаан станц байгуулах төслийг Японы хөрөнгө оруулагчидтай хамтран хэрэгжүүлэх сонирхлоо нотлов.

Япон Улсын Гадаад хэргийн сайдын айлчлал хоёр орны харилцааг шат ахиулан хөгжүүлэх, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг бататган бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.



2022.04.30-2022.05.02



"МОНГОЛ, ЯПОН, БИ, 50 ДУРСАМЖ"

Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Япон Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ-наас 2022 онд зохион байгуулсан "Монгол, Япон, Би, 50 дурсамж" мини зохион бичлэгийн уралдааны бүтээлүүдээс

Б.Түшиг-Эрдэнэ

Монгол хэл

Япон нутагт ажлын бус цагаар хийдэг ажил маань монгол хэл заах байсан юм. Хэдхэн сурагчтай, гэрийн даалгавар шалгадаггүй манай ангид нэг өдөр залуухан шинэ хүн ирлээ. Монгол хэлний олон номын цуглуулгатай хэрнээ монгол хэлээр нэг ч үг мэддэггүй түүнээс яагаад монгол хэл сурах болсныг нь асуулаа.

Эдгээр ном, монголоор бичсэн дэвтрүүдийг ээж минь хэрэглэж байсан юм. Ээж минь нэг ч удаа Монгол явж үзээгүй ч "Монгол явна, би Монголд дуртай гэдэг байсан. Би ээжийнхээ хүслийг биелүүлж Монголд аялах зорилготой байгаа, тиймээс энэ сургалтад ирсэн" гэлээ.

Цаг хугацаа эргэлдсээр нэг жил өнгөрч танил хэдэн хүн нийлээд нэг баг болж зуны дэлгэр цагаар Монголд ердөө тав хоног аялсан юм. Энэ аялалд багтсан тэр залуу Монголд ирээд япон хэлний орчуулагч охинтой танилцаж Япон, Монголын хооронд нэгэн жим гарчээ.

Дахин нэг жил өнгөрөхөд манай сурагч гэртээ өөрийн монгол хэлний багштай болсон байлаа. "Энэрлийн ивээлээр хайртай ээжийнх нь хүүдээ үлдээсэн ном дотор нь ЗАМ байсныг тэр олон жилийн дараа ойлгосон" гэж хэлсэн юм. Тэгээд дахин нэг жил болоход гурвуулаа, дахин нэг жил өнгөрөхөд дөрвүүлээ болсон байсан.

Та нартаа аз жаргал хүсье. Монгол хэлний багшаас нь...

Сато Жюн

Амьдралыг харах үзлийг минь өөрчилсөн Монгол

Арван хэдэн жилийн өмнөх явдал. Компаниас шинэ зах зээлийн эрэл хайгуул хийх болж, багийн шийдвэрээр томилолтоор Монголд анх хөл тавьсан юм. Тэр болтол би ажил, гэрийн хооронд явж, өдөр нь хурал, орой нь шөнө дөл болтол илүү цагаар ажилладаг жирийн нэг ажилтны амьдралаар амьдардаг байв. Харин дээрх томилолт миний амьдралыг харах үзлийг 180 хэм өөрчилсөн юм.

Өдөр бүрийг хөгжилтэй өнгөрүүлж, сэтгэл хангалуун амьдрах нь чухал гэдгийг ойлгож, миний үзэл бодол, аливааг хийх хандлага ч аяндаа өөдрөг болсон. Үнэхээр л дэлхийн түүхэнд хамгийн том газар нутагтай байсан "Монголын эзэнт гүрэн". Мэдээж газар нутгаараа том бөгөөд хүн зонь нь санаа бодлын уужмыг бусад ямар ч улс орны хүмүүстэй харьцуулахын аргагүй.

Түүнээс хойш Монголоор "өвчилсэн" би гэр бүлээ дагуулж Монголд гурван жилийн хугацаанд 15 орчим удаа очиж байсан. Элсэн манханд авирч, хоёр метр мөс цоолон загас барьж, тэнгэрт битүү түгсэн оддыг харангаа хамтдаа дуу дуулж байсан маань сэтгэлийг минь баясгасан, юугаар ч сольшгүй мөчүүд юм. Баярлалаа. Дахиад очноо.

Ш.Чимэг

Хүндлэлийн Япон

Одоогоос хоёр жилийн өмнө “Нарита” олон улсын нисэх буудалд бугаад Япон Улс руу нэвтрэхийн тулд шалганаар бүртгүүлэхээр дугаарлан зогсч байхад маш эелдэгээр “Монгол хүн, Хакухогийн нутгийн хүн байна. Тавтай морилно уу” гээд 70 орчим насны өвөө мэхийн хүндэтгэж байв. Тэр мөчөөс эхлээд Японд миний хамгийн их мэдэрсэн зүйл бол ХҮНДЛЭЛ.

Гудамж, дэлгүүр, хоолны газар, зочид буудал, метро гээд бүх л газар хүмүүс маш хүндэтгэлтэй хандана. Улс нь иргэддээ хүндэтгэлтэй ханддагийн тод илрэл нь тухайн орны, хотын хөгжил. Явган зорчигчийн, машинтай хүний, метронд зорчиж байгаа бүх хүний ая тухыг нь бүрэн хангасан, тухлаг орчинтой.

Иргэн нь улсаа, улс нь хүнээ боддог газар л ийм их хүндэтгэл оршдог юм байна гэсэн бодол төрж байсан юм.

Миний буусан буудалд олон улсын тэмцээний зочдын хөл хөдөлгөөн ихтэй байсан. Тэр буудалд буусан бүх тамирчдыг явах болоход буудлын бүх ажилчид /угтагч, үйлчлэгч, менежер, бүр тогооч нь хүртэл/ баг, тамирчдад амжилт хүсч, эгнэн зогсч байгаад бөхийн ёслоод үдэж өгч байв.

Мэдээж зочид буудал бол бизнес учраас үйлчлүүлэгчээ тав тухтай орчинд байлгаж, дараа дахин ирэх хүсэл төрүүлэх боловч эрхэлсэн ажилдаа чин сэтгэлээсээ, үйлчлүүлж байгаа хүндээ хүндэтгэлтэй хандаж байгаагийн том илрэл гэж дүгнэж байна.

Миний Японд зочилсон цөөхөн хэд хоногт бусдыг, өөрийгөө хүндэл, бүтээн байгуулалт, бусдын хөдөлмөр, ер нь хорвоо ертөнц дээрх бүх зүйлийг л ХҮНДЭТГЭХ, ХҮНДЛЭЛ байх ёстойг мэдрүүлсэн өдрүүд байсан юм.

Наритагийн онгоцны буудалд нэвтрэхээс эхэлсэн хүндлэл Японыг орхих мөчид ч, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн олон сая зочлодог мэдрэгдсэн, мэдрэгдсээр ч байх болов уу.



Мянганы Сорилтын сантай II компакт гэрээ байгуулав

Нийслэлчүүд ундны цэвэр усны 100 жилийн баталгаат эх үүсвэртэй болно

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2018 онд Монгол Улсын Ерөнхий сайдын хувиар АНУ-д албан ёсны айлчлал хийх үеэрээ Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Мянганы сорилтын корпорацын Удирдах зөвлөлийн дарга Майкл Помпеогийн хамт Компакт гэрээг албажуулж, Хамтарсан тунхаг бичигт гарын үсэг зурсан юм.

АНУ-ын Мянганы сорилтын корпорацын 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.76 сая ам.доллар, нийт 461.76 сая ам.долларын санхүүжилт бүхий Компакт гэрээ нь нийслэл Улаанбаатар хотыг аюулгүй, найдвартай усаар хангах зорилготой юм.

Монгол Улсад анх удаа ус гүн цэвэршүүлэх болон хаягдал ус дахин боловсруулах хоёр томоохон үйлдвэр байгуулж, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг сайжруулах цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ.



Компакт гэрээг цогцоор нь хэрэгжүүлснээр нийслэлчүүд ундны цэвэр усны 100 жилийн баталгаатай болно.





"462 сая ам. долларын энэ хөрөнгө оруулалт хоёр орны ард түмний түншлэлийн бэлгэ тэмдэг"

АНУ-ын Зүүн Ази, Номхон далайн хэрэг хариуцсан Туслах Төрийн нарийн бичгийн дарга Даниел Ж.Критенбринк.


"Дэлхийн хамгийн их усны хөмсдол, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөж болзошгүй Улаанбаатар хотод энэ үйлдвэрийг барьснаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдийг аюулгүй, тогтвортой усаар хангаж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ"

АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн Компакт гэрээний үйл ажиллагааны газрын Дэд ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Камерон Алфорд

Чингэснээр Улаанбаатар хотын ус хангамж 80 гаруй хувиар нэмэгдэж, нийслэл хот баруун тийш өргөжин тэлэх, энэ хэмжээгээр эдийн засаг өсөх таатай боломж бүрдэх юм.

Түүнчлэн төв цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн хаягдал усыг дахин боловсруулж, дулааны цахилгаан станцуудад ашиглах замаар томоохон аж үйлдвэрийн байгууламжуудын ашигладаг гүний усны эрэлтийг бууруулна.

Өдөрт 50 мянга, жилд 18 сая шоо метр усыг дахин боловсруулснаар Улаанбаатар хотын орон сууцанд амьдарч буй нийт айл өрхийн жилийн усны хэрэглээний 50 хувийг хангахуйц хэмжээний гүний цэнгэг усыг хэмнэх боломж бүрдэнэ.



Нийт хүн амын тал хувь нь оршин суудаг нийслэлийн усан хангамжийн найдвартай байдлыг бүрдүүлэх, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах зорилго бодит ажил болж байгаад баяртай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Угнаагийн Хүрэлсүх

БНСУ-тай харилцаа, хамтын ажиллагааг үндсэн таван чиглэлээр хөгжүүлнэ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцааг нэг шат ахиулав

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ МҮН
ЖЭ ИН-ТЭЙ 2021 ОНЫ
9 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР
ДЭЭД ТҮВШНИЙ ЦАХИМ
УУЛЗАЛТ ХИЙВ.

Төрийн тэргүүн нар хоёр улсын харилцааг “Стратегийн түншлэл”-ийн түвшинд дэвшүүлэн хөгжүүлэхээр тохиролцож, Хамтарсан тунхаглал гаргав.

Хамтарсан тунхаглалд Монгол Улс, БНСУ-ын Стратегийн түншлэлийн харилцааг:

1. Улс төр, аюулгүй байдал,
2. Худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засаг,
3. Боловсрол, шинжлэх ухаан-технологи, байгаль орчин, эрүүл мэнд,
4. Соёл, аялал жуулчлал, иргэдийн харилцаа,
5. Бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагаа гэсэн таван тулгуур чиглэлд өргөжүүлэн хөгжүүлэхээр тохирч, салбар тус бүрээр харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх зорилгыг тодорхойлов.

Хамтарсан судалгааны үр дүнд үндэслэн “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийн яриа хэлэлцээг 2023 онд эхлүүлж, хоёр талын хэлэлцээний баг байгуулна.





“Иж бүрэн түншлэл”-ийн харилцааг “Стратегийн түншлэл”-ийн түвшинд дэвшүүлэн хөгжүүлэх талаар анх ярилцаж байсан нь ажил хэрэг болж байгаад сэтгэл хангалуун байна.



Монгол Улсын Ерөнхийлөгч Угнаагийн Хүрэлсүх



АЙЛЧЛАЛЫН ҮР ДҮН:

- Экспортыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, худалдааны саад тотгорыг бууруулах, эрх зүйн орчныг улам бэхжүүлэх хүрээнд “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийн яриа хэлэлцээг эхлүүлэх,
- Тээвэр логистик, эрчим хүч, уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэхэд түлхүү анхаарах,
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлал, соёл, урлаг, соёлын бүтээлч үйлдвэрлэл зэрэг салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх,
- БНСУ-ын тал Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, “Ногоон хэрэм” төслийн III шатыг хэрэгжүүлэх,
- Хүүхэд, залуучуудын солилцоог дэмжиж, биений тамир, спорт, боловсрол, шинжлэх ухаан-технологи, мэдээллийн технологи, хүний нөөцийн хөгжлийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- БНСУ дахь Монгол судлал, Монгол Улс дахь Солонгос судлалыг хөгжүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллахаар болов.

2022.08.28-2022.08.30





Пак Жин

БНСУ-ын Гадаад хэргийн сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ МОНГОЛ УЛСАД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙСЭН БНСУ-ЫН ГАДААД ХЭРГИЙН САЙД ПАК ЖИНИЙГ 8 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ.

Уг айлчлал БНСУ-ын Гадаад хэргийн сайдын түвшинд найман жилийн дараа хэрэгжсэн бөгөөд хоёр улсын өнгөрсөн 30 жилийн харилцааг дүгнэн, ирэх 30 жилийн хамтын ажиллагааны хэтийн төлөв, замын зураглалыг тодорхойлоход чухал ач холбогдолтой болов.

Монгол Улс, БНСУ-ын Стратегийн түншлэлийн тухай хамтарсан тунхаглалын мөрөөр хэрэгжүүлж буй бодит ажлуудыг дүгнэн хамтын ажиллагааг таван тулгуур чиглэлээр өргөжүүлэн бэхжүүлэх талаар тохиролцов.

Монгол Улсын “Алсын хараа 2050” урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг БНСУ-ын шинэ Засгийн газрын бодлоготой уялдуулан тээвэр, логистик, эрчим хүч, дэд бүтцийн салбарт үр ашигтай хамтран ажиллах, бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэхээр болов.

Энэ хүрээнд Солонгосын “K-City Network”, “Smart Farm” төслийг Монгол Улсад хэрэгжүүлж, хамтын ажиллагааг эрчимжүүлэхээр тохиролцов.

“Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлыг бүс нутгийн хэмжээний тээвэр, ложистикийн зангилаа болгох, Хөшигийн хөндийд шинэ хот, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах хүрээнд хамтран ажиллахаар болов.

Худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах чухал ач холбогдолтой “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулах яриа хэлэлцээг эхлүүлж, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг шинэчлэх ажлыг эрчимжүүлэхээр болов.

Газрын ховор элемент, хагас дамжуулагчийн түүхий эд нийлүүлэхэд БНСУ-тай хамтран ажиллах, энэ хүрээнд хамтарсан судалгааны төвийг Монгол Улсад байгуулахаар болов.

Талууд “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд хамтран ажиллахаар болов.

Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэхэд чиглэсэн санаачилгыг БНСУ дэмжиж, “Ногоон хэрэм” III шатны төслийн хүрээнд нийт 45 га талбайд мод тарьж ургуулахаар болов.

Иргэд харилцан зорчих таатай нөхцөл бүрдүүлэх, эмчилгээний зорилгоор зорчих монгол иргэдэд визийн нөхцөлийг хөнгөвчлөх, цаашид харилцан визгүй зорчих чиглэлд ахиц гаргахын төлөө хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллахаар тогтов.

БНСУ нь Монгол Улсын Зүүн Азийн дээд түвшний уулзалтад оролцогч улс болох, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх саналыг дэмжиж буйгаа анх удаагаа илэрхийлэв.

Солонгос иргэдийг галын аюулаас аварсан эрэлхэг Монгол залуусын түүх

Солонгос иргэдийг галын аюулаас аварсан дөрвөн монгол залуугийн баатарлаг мөртлөө хөгжилтэй түүх тухайн үедээ Монгол, Өмнөд Солонгосын иргэдийн дунд ихээхэн алдаршиж байв.

Учир нь Сөүл хотын Гуро-гу дүүргийн Шиндорим-донг дахь орон сууц, худалдааны цогцолборын барилгад 2007 оны 3 дугаар сарын 17-ны өглөө гал гарч, тэнд байсан 11 иргэн амь насаа алдах эрсдэлд орсон байсныг дөрвөн монгол залуу аварсан юм. Тэд солонгос иргэдийн амь насыг аврах үеэрээ бэртэж гэмтэцгээсэн тул тухайн газраасаа шууд эмнэлэгт хүргэгджээ.

Хөгжилтэй нь олон иргэний амь насыг аварсныхаа дараа эмнэлэгт эмчлүүлж байхдаа нэрээ нууцалж, улмаар оргон зугтсан байна. Шалтгаан нь БНСУ-д хууль бусаар оршин сууж байсан тул баривчлагдаж, Монгол руу хүргэгдэнэ гэж айцгаажээ. Тэд 1-4 жил хууль бусаар БНСУ-д амьдарч, барилгын ажил хийж байсан юм.


Өмнөд Солонгосын албаныхан баатарлаг үйлс бүтээсэн дөрвөн монгол иргэний эрэлд гарч, БНСУ-ын Хууль зүйн яамнаас “11 хүний амь насыг аварсан хүмүүсийн эр зоригийг үнэлэн дөрвөн иргэнд хууль ёсоор оршин суух зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн” гэж мэдэгдсэн байна. Тус улсын Цагаачлалын

хяналтын тухай хуулийн дагуу хууль бусаар ажиллаж буй гадаадын иргэдийг БНСУ-д онцгой хувь нэмэр оруулсан тохиолдолд оршин суух зөвшөөрөл өгч болдог бөгөөд анх удаа уг зохицуулалтыг хэрэгжүүлэх гэж байсан нь энэ юм.

Хууль зүйн яамны Мөрдөн байцаах, гүйцэтгэх албаны ажилтан Пак Жэ Ван “Бид Монголын Элчин сайдын яам болон Сөүлийн цагаачлалын албанд хандан дээрх дөрвөн хүний нэрийг тогтоон, олж өгөхийг хүссэн. Тэднийг ирээдүйд ямар салбарт ажиллахыг мэдээд, тухайн үйлдвэрт нь хууль ёсны дагуу үлдэхийг зөвшөөрөх болно. Хэрэв тэд барилгын салбарт ажиллах хүсэлтэй бол мэргэжлийн бус хөдөлмөрийн визээр гурван жил байх боломжтой” гэж мэдээлжээ.

БНСУ-ын Ури намын төлөөлөгч Жан Жун Сун, Солонгос-Монголын найрамдлын нийгэмлэгийн ерөнхийлөгч Ким Дун Чол нар ч Хууль зүйн яаманд хандан эдгээр иргэдийн асуудалд анхаарал хандуулахыг хүсжээ.

Ийнхүү галын аюул руу амь өрсөн орж, 11 солонгос хүний амь насыг нь аварсан дөрвөн монгол залуу эрэлхэг гавьяаныхаа төлөө БНСУ-д хууль ёсоор оршин сууж, ажил эрхлэх зөвшөөрөлтэй болж байсан юм.





2016 남대문시장 FESTA

Korea Sale FESTA 기간: 2016. 9.29(목) ~ 10.31(월) 까지
일시: 2016. 9.29(수) ~ 10.31(금) 장소: 남대문시장

2016 남대문시장 FESTA

Namdaemun Market FESTA 南大門市場FESTA
Korea Sale FESTA 기간: 2016. 9.29(목) ~ 10.31(월) 까지
일시: 2016. 9.29(수) ~ 10.31(금) 장소: 남대문시장


WORLD TOUR

자연주의적 삶 NATURE

Агаарын тээврийн салбарт эрс өөрчлөлт гаргав

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд нислэгийн ТООГ НЭМЭГДҮҮЛЭВ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН САМАРКАНД ХОТНОО БОЛСОН ШХАБ-ЫН ГИШҮҮН ОРНУУДЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ӨРГӨТГӨСӨН ХУРАЛДААНД ОРОЛЦОХ ҮЕЭРЭЭ БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Р.Т.ЭРДОАНТАЙ 2022 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР УУЛЗАВ.



Талууд хоёр улсын орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг онцолж, 2022 онд хоёр орны худалдааны эргэлт 100 сая ам.долларт хүрэх төлөвтэй байгааг сайшаан тэмдэглэв.



- Уулзалтаар 2024 онд Монгол Улс, БНТУ хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойн хүрээнд дээд, өндөр түвшинд харилцан айлчлал хэрэгжүүлэх, Иж бүрэн түншлэлийн харилцааг шат ахиулах, шууд нислэгийн тоог нэмэгдүүлэх, Монгол Улсаас БНТУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох зэрэг асуудлаар санал солилцов.
- Уулзалтын мөрөөр УИХ-ын дарга Г.Занданшатар тус улсад 2022 оны 10 дугаар сард айлчлал хийсэн бол Монгол-Туркийн Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийн асуудлаарх уулзалт 2022 оны 12 дугаар сард Истанбул хотноо болов.
- Уулзалтын дүнд Монгол, Туркийн агаарын тээвэрлэгчид Улаанбаатар-Истанбул чиглэлд тус бүр долоо хоногт долоон удаа, Улаанбаатар-Анталья болон Анкара чиглэлд долоо хоногт тус бүр таван удаа шууд нислэг үйлдэхээр болов.
- “МИАТ” ТӨХК “Туркиш Эйрлайнс” компанитай гэрээ байгуулж, Амстердам, Барселона, Брюссель, Ром, Франкфурт, Вашингтон, Чикаго, Вена, Варшав, Цюрих хот руу “code-share” буюу аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалттай болов. Мөн эдгээр хотод карго ачаанд ч “code-share” хэрэгжинэ.
- Чингэснээр харилцан тийз борлуулах эрхтэй болсноос гадна монголчууд Истанбулаар дамжин АНУ, Европ, Ойрх Дорнодын 10 хот руу хамгийн хямд үнээр нисэх боломж бүрдэв.



“Туравдагч хөрш, Иж бүрэн түншлэлийн харилцаатай Бүгд Найрамдах Турк Улстай харилцаагаа өргөжүүлж, шат ахиулан хөгжүүлэх эрмэлзэлтэй байна.



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх



Монгол Улс, БНЧУ-ын хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ


Бүгд Найрамдах Чех Улстай Ойн менежментийн чиглэлээр идэвхтэй хамтран ажиллана



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Шарм Эль-Шейх хотноо болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад оролцох үеэрээ 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр Бүгд Найрамдах Чех Улсын Ерөнхий сайд П.Фиалатай уулзав.

Уулзалтаар харилцаа, хамтын ажиллагааг эдийн засаг, боловсрол, байгаль орчин зэрэг салбарт өргөжүүлэн хөгжүүлэх, ялангуяа “Ойн түншлэлийн тухай Монгол Улс, болон Европын Холбоо хоорондын Харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийн хүрээнд ойн менежментийн салбарт идэвхтэй хамтран ажиллах талаар санал солилцов.

Энэхүү уулзалт хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулах, дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, хоёр талын хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдолтой болсон.



Чех Улсад ажиллаж, амьдарч буй Монголын 12 мянга гаруй иргэний нийгмийн баталгаа хангагдаж, тэтгэврээ шилжүүлэн авах боломжтой болж байна. Тэтгэврийг Монгол Улс, БНЧУ-ын хууль тогтоомжийн хүрээнд шийдэх бөгөөд хэлэлцээрт Монгол Улсын Нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргийн, Тэтгэврийн даатгалын сан болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийн, харин БНЧУ-ын хувьд Тэтгэврийн даатгалаас олгох тэтгэврийн, Нийгмийн даатгалын шимтгэл, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх үүргийн тухай тэтгэвэр хамаарах аж.



"Монголчехметалл" ХХК-ийн
дэд захирал Л.Аюур

//

Чехийн монголжсон мэргэжилтнүүд

БНМАУ, БНСЧУ-ын Засгийн газар хооронд 1979 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу "Монголчехословакметалл" хамтарсан үйлдвэрийг 1980 онд байгуулж, 1982 оноос уул уурхайн үйлдвэрлэл нь эхэлсэн түүхтэй. Би энэхүү хамтарсан үйлдвэрийн инженер механикчаар томилогдон ажиллаж байв. Үйлдвэр маань Монгол-Оросын хамтарсан үйлдвэрийн дараа хоёрдугаарт бичигдэж, жилд 50 мянган тн жонш Европын зах зээлд гаргадаг байлаа.

Тухайн үед үйлдвэрт ажиллахаар Чехословакийн мэргэжилтнүүд байнга ирдэг байлаа. Тарвага агнахыг өнөөгийнх шиг хориглодоггүй байсан үе. Тиймээс биднийг дагаж идсээр байгаад мэргэжилтнүүд маань тарваганы маханд дуртай болоод нутаг буцдаг сан. Эхэндээ ч тарваганы мах чанаж, боодог хийхийг харсан чехүүд идэж чадахгүй. Тэгсээр сүүлдээ монголжиж, биднээс дутахгүй дуртай болно. Уурхайд ажиллаж байсан чех инженер маань нэг удаа тарваганы мах захиж, "Сайхан зоог бэлдчихье, хүрээд ирээрэй" гэж урилаа. Хоёр тарваганы мах бэлтгүүлээд чех ажилчдын гал тогоонд хүргүүлэв. Удалгүй оройн хоолонд яваад очив. Гэтэл өнөөх сайхан тарваганы махыг маань хоол амтлагчуудаар амталж, шарах зууханд болгочихож. Амт нь танигдахын аргагүй, ямар ч тарваганы мах гэх шинж алга аа. Болоогүй ээ, хажууд нь зууш, хачир тавиад рестораны хоол шиг таваглачихсан байж билээ.



Өөр нэг хөгжилтэй дурсамж сөхөхөд, чехүүд долоо хоногийн таван өдөр уурхайд ажиллаад, хоёр өдөр нь хотод амардаг байсан юм. Ерөнхий захиргааны үйлдвэр, техникийн хэлтсийн даргаар ажиллаж байсан чех нөхөр маань нэг өдөр "Би нутаг буцах дөхөж байна, хоёр тарваганы мах өгч явуулаач" гэв. Захисныг нь ажилчдын автобусанд дайгаад явуулсан чинь бусад нөхөд замаас нь идчихсэн, дараа нь хэн идсэн бэ гээд бөөн эрэл сурал, мөрдлөг болж билээ. Энэ бүхэн бол чех мэргэжилтнүүд маань бидний идэж, уудаг хоол унданд хүртэл дасаж, монголжсон байсны жишээ юм.

Ер нь Монгол Улсад уул уурхай, геологийн салбар эрчимтэй хөгжиж байх үед Чехословакийн ажилчин, инженер, мэргэжилтнүүд ихийг зааж сурган, олон ч монгол хүн тус улсад мэргэжил дээшлүүлсэн. Тэд ажлын цагийг чанд баримталдаг, төлөвлөлт сайтай, уурхайн дүрэм, журмыг хатуу мөрддөг байсан.

Хэдийгээр чехүүд нутаг буцсан ч цөөнгүй нь бидэнтэй холбоотой байж, хааяа харилцан мэндчилгээ илгээн, зарим нь амралтаараа Монголд ирдэг, бид бас ажил хэргээр Чех явахдаа уулздаг хэвээр байгааг тэмдэглэхэд таатай байна.





Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
Очирын Энхтөр

//

Ерөнхийлөгч Вацлав Клаус

"Irish pub"-д жааз хөгжмийн концерт үзэх дөхсөн нь

Намайг Чех Улсад Элчин сайдаар томилогдон очиход тус улсын Ерөнхийлөгч нь Вацлав Клаус байсан юм. Тэр хүнд Итгэмжлэх жуух бичгээ өргөн барьж танилцлаа. Карлын их сургууль төгссөн, чех хэлтэй гэсэн чинь ихээхэн тоож сонирхож байгаа юм. Ингээд хувийн аятайхан харилцаатай болсон. Бас хажуугаар нь чех хэлтэй Элчин сайд нарын бүлэг гэж ажиллаж, үйл ажиллагаагаараа Вацлав Клаус Ерөнхийлөгчтэй ойр дотно байнга харилцдаг нь ч завшаан болсон. Бас Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нь надтай цуг ажиллаж байсан хүнтэй их сургуульд цуг сурч байсан болж таарлаа. Манай найзын найз гэсэн үг шүү дээ. Ингээд найзалж эхэллээ. Яг тэр үе Жак Уэтерфордын "Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан" ном гарч, тэр номыг гарангуут нь чех хэлээр орчуулсан юм. Бараг хамгийн түрүүнд орчуулж гаргасан байх. Нөгөө номоо аваад Ерөнхийлөгч Вацлав Клаус гуай болон Тамгын газрын даргатай уулзаад "Энэ ийм учир, агуулгатай ном гарсан юм. Танайхан их аятайхан орчуулаад гаргасан байна" гээд өглөө. Бас л нэг харилцаагаа дотно байлгах, Монгол Улсаа сурталчлах хэлбэр юм. Чех Улс Европын холбоонд элсчихсэн, улстөрчид нь баруун руу илүү анхаарал хандуулдаг болчихсон тийм үе л дээ. Энэ дундуур "Монгол гэж эртний анд нөхөр чинь байгаа шүү" гэдгийг сануулна. Гэхдээ Вацлав Клаус Ерөнхийлөгч Монголд элэгтэй хүн байсан, тиймээс ч манай саналыг хүлээж авч 2006 онд Монгол Улсад айлчилсан юм.

Вацлав Клаус жааз хөгжимд их дуртай хүн. Би бас жааз сонсох дуртай талдаа. Сонирхол нэгтэй нь бас байнгын харилцаагаа хадгалах

үндэс болчихож байгаа юм. Тэр үеэр 1968 онд Монголд ирээд Богд уулын хавьцаа осолдож багаараа шахуу нас барсан Чехословакийн алдартай жааз хамтлагт байсан чех эхнэртэй нэг хөгжимчинд Вацлав Клаус үүрэг өгөөд "Прагийн шилтгээн дэх жааз" гээд цуврал концерт тоглуулдаг байв. Өөрөө байнга оролцож жааз хөгжим сонсдог, бас хоёр, гурван Элчин сайдыг урьдаг байсан юм. Намайг бол бүх концертдоо урина. Тэнд очихоор Ерөнхийлөгч болон Тамгын газрын даргатай байнга уулзана. Монголын талаас Чехийн Ерөнхийлөгчийг Монголд айлчлуулахаар хөөцөлдөж байсан үе ч таарсан. Чех-Монгол олон жилийн найрсаг харилцаатай, маш олон монголчууд энд сурч, дадлагажиж байсан. Одоо ч хэдэн мянгаараа Чехэд ажиллаж, амьдарч байна. "Та Монголд айлчилбал хэчнээн сайхан бэ" гээд тэр дунд бас л яриа хөөрөө байнга явна. Ингээд Вацлав Клаус 2006 оны 9 дүгээр сарын 25-27-нд Монгол Улсад айлчилсан. Айлчлалын албан ёсны арга хэмжээ ч сайхан боллоо. Тэгтэл Вацлав Клаус гуай надад хандаад "Өнөө орой жааз концерт юу байна, Монголд нэг жааз концерт үзчихсэн юм сан" гэж байна шүү. Чехэд төгссөнөөр нь "Шар айраг" хамтлагийн Г.Ганхүү рүү л залгалаа даа. "Манайд чинь жааз хөгжим тоглодог клуб энэ тэр юу байна" гээд, нөгөөх чинь "Өө яасан хэцүү хүсэлт вэ" гэв. Би ч "Чи л нэг аргалж үз, орой очно" гэж байгаа юм. Орой ч боллоо. Зочид "Кемпинский" зочид буудалд байрлаж байсан юм. Хамгаалалт нь тараад явчихлаа. Тэр үед Төрийн тусгай хамгаалалтын албаны дарга нь Тунсаг гээд бас Чехэд төгссөн хүн байж таарлаа шүү. Нөгөөх рүү чинь

залгаад "Ерөнхийлөгч ер нь орой жааз сонсож, гарч орж магадгүй болоод явчихлаа" гэж хэллээ. Тэр маань ч хамгаалалтынхнаа дор нь цуглуулаад нэг цагийн дараа цуваа явахад бэлэн болсон. Цаг нэлээн орой болчихсон. Тэгсэн Вацлав Клаус Ерөнхийлөгч "Цаг ч орой болчихлоо, одоо больё доо" гэж байна шүү. Хамт явсан Гадаад харилцааны яамны орлогч сайд бусад хүмүүс нь "Нэгэнт ингэж бэлтгүүлчихээд эвгүй юм биш үү, орой болсон ч явахгүй бол болохгүй" гээд... Ерөнхийлөгч өөрөө яваагүй. Харин хамт явсан хүмүүс нь Драммын театрын ард байдаг "Irish pub"-д ирж Г.Ганхүүгийн бэлтгэсэн жааз хөгжмийн концерт үзэж, сигар татаад "Монголд, Улаанбаатарт дажгүй байдаг юм байна шүү" гээд хөгжилдсөн сөн. Тухайн өдөр арай эртхэн зохион байгуулж чадсан бол Ерөнхийлөгч Вацлав Клаус Монголд жааз хөгжмийн концерт үзэх байсан юм даа...

Айлчлалын үеэр Чехийн "Млада фронта" сонинд Вацлав Клаус өдөр болгон "Монголд айлчиллаа. Ийм тийм байна" гээд одоогийнхоор бол жиргээ (twitter) маягаар Монголын талаар их аятайхан богино богинохон сэтгэгдлүүдээ бичсэн байж билээ.

Эцэст нь өгүүлэхэд, Монголд Элчин сайдаар ажиллаж байсан Иржи Бродский (энэ хүн Вацлав Клаус Ерөнхийлөгчийн гадаад харилцааг хариуцдаг байв) нар санаачлан Вацлав Клаус гуайн бичсэн "Супермаркетаас ч илүүг хүссэн юм сан" номыг 2019 онд монгол хэлээр орчуулж гаргасан. Номын нээлтийг хийхдээ түүнийг Монголд урьж авчрахыг хүссэн боловч "нас өндөр болж, хол явж чадахааргүй байна" гээд ирж чадаагүй юм.

2023 он

Нэг тэрбум ам. долларыг эх орондоо үлдээх боломж бүрдэнэ

Хэрэгцээт түлш, шатахуунаа дотоодоос хангах цаг ойртсоор

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭР БАРИХ
ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ЦАР ТАХЛААС
УЛБААТАЙ ҮНИЙН ӨСӨЛТ, ТЭЭВЭР ЛОЖИСТИК
ЗЭРЭГ ХҮНДРЭЛТЭЙ ҮЕИЙГ ДАВАН ТУУЛЖ,
ЭРГЭН ИДЭВХЖИЖ БАЙНА.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийг Шадар сайдаар ажиллах байх үед Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Модри 2015 оны 5 дугаар сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад зориулж 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн шугамыг нээхээр шийдвэрлэснээ мэдэгдсэн. 2016 оны 11 дүгээр сард Шинэ Дели хотноо болсон Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын чуулга уулзалтад оролцох үеэрээ Ерөнхий сайд Н.Модри-той уулзаж, энэтхэгийн талаас олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсад “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэх саналтай буйгаа илэрхийлсэн. Монгол Улсын Их Хурал зээлийн хэлэлцээрийг 2017 оны 5 дугаар сард соёрхон баталснаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн бүтээн байгуулалтын ажил эхэлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн урилгаар 2018 оны 6 дугаар сард БНЭУ-ын Дотоод хэргийн сайд Ражнат Сингх Монгол Улсад албан ёсны айлчлал хийж “Газрын тосны боловсруулах үйлдвэр”-ийн шав тавих ёслолд оролцсон нь үйлдвэрийн ажлыг эрчимжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 11 дүгээр сард Глазгоу хотноо болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад оролцох үеэрээ Энэтхэгийн Ерөнхий сайд Н.Модри-той дахин уулзаж боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж байгаа талаар дэлгэрэнгүй ярилцав.







Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх үйлдвэрийн шавыг тавив. 2018 оны 6 дугаар сар.

Үйлдвэр ашиглалтад орсноор 1,5 сая тонн түүхий тос боловсруулж, 1,3 сая орчим тонн түлш, шатахуун үйлдвэрлэнэ. Тухайлбал дизелийн түлш 824 мянган тонн, автобензин 339 мянган тонн, онгоцны түлш 80 мянган тонн, шингэрүүлсэн шатдаг хий 43 мянган тонн, зуухны түлш 43 мянган тонныг зах зээлд нийлүүлэх юм. Чингэснээр хэрэгцээт түлш, шатахуунаа дотоодоос бүрэн хангахын зэрэгцээ импортоор шатахуун авахад зарцуулдаг тэрбум орчим ам.доллар эх орондоо үлдэнэ.

Эхний багц ажлын барилга угсралт 2023 оны II улиралд дуусах бөгөөд дараагийн багцууд үйлдвэрийн үндсэн технологийн болон хэрэглээний ба дагалдах байгууламжуудаас бүрдэх юм. 2022 онд хоёр, гуравдугаар багц болон дамжуулах хоолойн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг нь эхлүүлээд байна.

Энэ төсөл эрчим хүчний бие даасан байдлыг хангах, нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавих, байгалийн баялгаа боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаад худалдааны тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх, бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, говийн бүсэд аж үйлдвэрийн шинэ төв бий болгох зэрэг чухал ач холбогдолтой юм. Мөн энэхүү үйлдвэр нь Монгол-Энэтхэгийн харилцан хамтын ажиллагаа, найрамдал нөхөрлөлийн илэрхийлэл болсон бүтээн байгуулалт болох юм.



2022.09.05–2022.09.07

Ражнат Сингх

БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧ У.ХҮРЭЛСҮХ БНЭУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД РАЖНАТ СИНГХИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ.

Монгол Улсын оюун санааны түнш, гуравдагч хөрш БНЭУ-тай харилцаа, хамтын ажиллагаа олон салбарт өргөжин хөгжиж байгааг Ерөнхийлөгч тэмдэглэж, үүнд БНЭУ-ын Ерөнхий сайд Нарендра Модигийн 2015 онд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал болон Батлан хамгаалахын сайдын энэ удаагийн айлчлал чухал түлхэц болж байгааг онцлов. Мөн хоёр орны хооронд тогтоосон Стратегийн түншлэлийн харилцааг Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүргэх бүрэн боломж байгааг хэлэв.

Энэ удаагийн айлчлал нь итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах, харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэн, өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Айлчлалын үеэр сайд Ражнат Сингх Кибер аюулгүй байдлын төв болон Энэтхэг-Монголын найрамдалт ерөнхий боловсролын сургуулийн шавь тавих ёслолд оролцов.



Он цагийн товчоон

**2017.02 сар**

Төслийг Монгол улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импортын банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

2017.04 сар

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК байгуулав.

2017.05 сар

Зээлийн ерөнхий хэлэлцээрийг УИХ соёрхон батлав.

2020.10 сар

ЕРС 01 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан БНЭУ-ын "Жэй Эм Си Прожектс Индиа" компанитай гэрээ байгуулав.

2020.08 сар

Бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зэрэг үүрэг бүхий Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулав.

2019.10 сар

27 км төмөр зам, 18 км авто зам, 18,6 км ЦДАШ-ыг ашиглалтад хүлээн авав.

2021.01 сар

УИХ Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль батлав.

2021.01 сар

"Жэй Эм Си Прожектс Индиа" компани технологийн бус барилга байгууламжийн барилга угсралтын ажлаа эхлэв.

2021.04 сар

Газрын тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендер зарлав.

2021.08 сар

"Төрөөс дэмжлэг үзүүлэх тухай" журмыг Засгийн газар батлав.

2023.01 сар

ЕРС 04 багц ажлын тендерт оролцогчдын материалыг хүлээн авав.

2022.10 сар

Үйлдвэрийн лицензтэй технологийн байгууламжуудын Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлав.

2022.10 сар

БНЭУ-ын "Меҗа Инженеринг Инфрастракчр Лимитед" компанитай "Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын гэрээ" байгуулав.

2022.09 сар

"Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл"-ийн бакалаврын анги шинээр нээж, тэтгэлэгтэй хөтөлбөр зарлан, оюутнуудыг сургаж эхлэв.



Үйлдвэрийг 2025 онд ашиглалтад бүрэн оруулахаар төлөвлөж байна. Ингэснээр Монгол Улс түлш шатахууны хэрэгцээгээ дотоодоосоо хангах бүрэн боломжтой болно.

2018.01 сар

Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх Засгийн газрын тогтоол гарав.

2018.06 сар

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт үйлдвэрийн шавыг тавив.

2018.11 сар

Үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг хүлээн авав.

2019.04 сар

Сайншанд хотод 550 айлын орон сууцны хотхон байгуулах Засгийн газрын тогтоол гарав.

2019.10 сар

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр болох 236 сая ам.долларын Зээлийн хэлэлцээр байгуулав.

2019.05 сар

Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулав.

2020.03 сар

Италийн "Прометеус" компанитай лицензтэй байгууламжуудын ерөнхий зураг төсөл, инженерчлэлийн багц ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулав.

2021.10 сар

УИХ-ын Байнгын хороо бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар тогтоол гаргав.

2022.01 сар

Патенттай технологийн 7 байгууламжийн лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж дуусав.

2022.04 сар

Олон улсын тендерт шалгарсан БНХАУ-ын "Норинко интернэйшнл Кооперейшн" компанитай гэрээ байгуулав.

2022.06 сар

Газрын тос дамжуулах хоолой барих ажил эхлэв.

2022.09 сар

Хотхоны эхний ээлжийн орон сууцныг ашиглалтад оруулав.

2022.06 сар

Үйлдвэрийн анхдагч процессын болон дагалдах байгууламжуудын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлав.

2022.05 сар

Үйлдвэрийн цахилгаан станцын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлав.

Збигнев Рау

Польш Улсын Гадаад хэргийн сайд

БҮГД НАЙРАМДАХ
ПОЛЬШ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН
САЙД БӨГӨӨД
ЕВРОПЫН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ
БАЙГУУЛЛАГЫН
2022 ОНЫ ДАРГА
ЗБИГНЕВ РАУ 2022
ОНЫ 6 ДУГААР
САРЫН 6-НЫ ӨДӨР
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
У.ХҮРЭЛСҮХЭД
БАРААЛХАВ.



2022.06-04-2022.06.06



Хэлэлцээний үеэр худалдаа, эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, Тавантолгойн дулааны цахилгаан станцын төсөлд хамтран ажиллах, соёл, боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар санал солилцов.

Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч А.Дудаг Монгол Улсад айлчлуулах, энэ хүрээнд Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол, Польшийн Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах, Монгол Улсын Архивын ерөнхий газар, Бүгд Найрамдах Польш Улсын Төрийн архивын газар хооронд Санамж бичиг байгуулах, Польш Улсад хадгалагдаж буй 1915 оны Монгол Улсын хүн амын тооллогын баримт зэрэг Монголын түүхтэй холбогдох баримт бичгийг хамтран судалж, хуулбарлан авах чиглэлээр хамтран ажиллахаар болов.

Эбэрхард Цорн

ХБНГУ-ын Холбооны Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга



2022.06.16–2022.06.19



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧ У.ХҮРЭЛСҮХЭД ХБНГУ-ЫН ХОЛБООНЫ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ГЕНЕРАЛ ЭБЭРХАРД ЦОРН 2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР БАРААЛХАВ.

Монгол Улсын Ерөнхийлөгч хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа олон чиглэлд өргөжин хөгжиж, тэр дундаа батлан хамгаалах салбар, цэргийн хамтын ажиллагаа өргөжин тэлж байгааг онцлов. Цаашид хамтын ажиллагаа өргөжиж, олон шинэ чиглэлд хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв.

Генерал Эбэрхард Цорн хоёр улсын цэргүүд олон жилийн турш Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад хамтран үүрэг гүйцэтгэсэн бөгөөд, үүнд Монгол Улсын Зэвсэгт хүчний тусламж дэмжлэг, үүрэг, хариуцлага өндөр байсныг онцлов. Цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжил, дэвшлийг тууштай дэмжиж ажиллахаа илэрхийлэв.

Генерал Эбэрхард Цорн айлчлалынхаа үеэр хоёр улсын Зэвсэгт хүчний хамтарсан Уулын явган цэргийн хээрийн сургуулийн үйл ажиллагаа, сургалт, бэлтгэлтэй танилцав.



2022.09.03–2022.09.05

Салөмсай Гуммасит

*БНАЛАУ-ын Ерөнхий
сайдын орлогч, Гадаад
хэргийн сайд*

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ БНАЛАУ-ЫН
ЕРӨНХИЙ САЙДЫН ОРЛОГЧ,
ГАДААД ХЭРГИЙН САЙД
САЛӨМСАЙ ГУММАСИТЫГ
9 ДҮГЭЭР САРЫН 4-НИЙ
ӨДӨР ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ.

Ерөнхийлөгч Монгол, Лаосын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд БНАЛАУ-ын Ерөнхий сайдын орлогч, Гадаад хэргийн сайдын хийж буй айлчлал хоёр улсын уламжлалт найрсаг харилцааг ирэх шинэ жаранд хөгжүүлэхэд чухал түлхэц болно гэдгийг онцлов.

Айлчлалын үеэр найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэх, улс төрийн яриа хэлэлцээг идэвхжүүлэх, худалдаа, эдийн засаг, соёл болон бусад салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр тохиролцов.

Энэ хүрээнд Монгол, Лаосын харилцааны чухал механизм болох Засгийн газар хоорондын комиссын XII хуралдааныг Вьентьян хотноо зохион байгуулахаар болов.

Монгол, Лаос, Хятадын зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын хооронд гурван талт хамтын ажиллагааг эхлүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд транзит тээврийн хэлэлцээр байгуулах чиглэлд хүчин чармайлт гарган хамтран ажиллахаар тогтов.

БНАЛАУ нь Монгол Улсын Зүүн Азийн дээд түвшний уулзалтад оролцогч улс болох, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад элсэх саналыг дэмжиж буйгаа нотлов.

Айлчлалын үеэр “Хамтран ажиллах тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Гадаад хэргийн яам хоорондын Харилцан ойлголцлын Санамж бичиг” болон “2022-2027 онд оюутан солилцох тухай Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Боловсрол, спортын яам хоорондын хэлэлцээр” байгуулав.

БНАЛАУ-ын Гадаад хэргийн сайдын түвшинд 20 жилийн дараа Монгол Улсад хэрэгжсэн энэ айлчлал нь хоёр улсын уламжлалт найрсаг харилцааг ирэх шинэ жаранд хөгжүүлэх хэтийн төлөв, хамтын ажиллагааны чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой болов.



2022.10.09–2022.10.13

Жорж Ж.Фюри

Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХЭД КАНАД УЛСЫН ПАРЛАМЕНТЫН СЕНАТЫН ТАНХИМЫН ДАРГА ЖОРЖ Ж.ФЮРИ 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР БАРААЛХАВ.

Уулзалтын үеэр худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, батлан хамгаалах, энхийг сахиулах, байгаль орчин, боловсрол зэрэг салбарын харилцаа, хамтын ажиллагаа болон олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцож, мөн Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон “Ерөнхийлөгчийн илгээлт – 2100” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах талаар ярилцав.

Монгол Улс, Канад Улсын харилцаа нь хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн ардчиллын нийтлэг үнэт зүйлсэд тулгуурлан “Өргөн хүрээтэй түншлэл”-ийн хүрээнд хөгжиж байна.

Канад Улс нь Монгол Улсын чухал “гуравдагч хөрш” бөгөөд Сенатын танхимын дарга Ж.Фюригийн айлчлал хоёр талын харилцааг “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүргэх зорилтыг урагшлуулах, харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд өндөр ач холбогдолтой үйл явдал болов.

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Б.БАТЦЭЦЭГ

Хоёр хөрш болон гуравдагч түнш орнуудтай тэнцвэртэй хамтын ажиллагааг улам идэвхжүүлэхэд онцгой анхаарч ажиллана



- Бидний урилгын хүлээн авч ярилцлага өгч байгаад баярлалаа. Энэ онд манай улс гадаад харилцааны чиглэлээр идэвхтэй, олон онцлог үйл явдлуудаар дүүрэн жил болж өнгөрлөө. Нөгөө талаар олон улсын харилцаанд томоохон өөрчлөлт орж, геополитикийн нөхцөл байдал ээдрээтэй болж, дэлхийн өнцөг булан бүрт тогтворгүй, хурцадмал байдал үргэлжилсээр байна. Энэхүү нөхцөл байдалд Монгол Улс ямар бодлого баримталж, гадаад бодлого явуулж байна вэ?

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, түүний араас завсаргүй залгасан геополитикийн ээдрээтэй байдал өнөөдөр Монгол Улсын энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Манай гадаад бодлогын амин сүнс нь харилцааны тэнцвэртэй харьцааг хадгалах явдал. Бид 2022 онд дээд, өндөр түвшинд хэмжээнд урьд өмнө байгаагүй олон айлчлал хэрэгжүүлж, олон баримт бичиг байгуулж, харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүллээ. Үүний дүнд бид дэлхий дахинд эрчим хүчний нийлүүлэлт тасалдаж, инфляц өсөж, мөнгөний бодлого чангарч, геополитикийн тодорхойгүй байдал даамжирснаас үүдэн дэлхийн эдийн засгийн өсөлт бүхэлдээ удааширч, Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ “амаргүй цаг үе” хэмээн тодорхойлоод байгаа энэ хүнд үеийг харьцангуй хохирол багатай даван туулах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж чадлаа. Өнгөрсөн хугацаанд манай гадаад харилцааны практикт хоёр сонирхолтой зүйл ажиглагдлаа. Эхнийх нь, дэлхий дахинд өрнөж байгаа үйл явц манай гадаад харилцааны үндсэн



Монгол Улс гадаад бодлогын үндсэн зарчмуудаа тууштай баримталж, хоёр хөрш болон гуравдагч түнш орнуудтайгаа тэнцвэртэй хамтын ажиллагааг улам идэвхжүүлнэ.

зарчмууд, гадаад бодлогын үзэл баримтлал эхнээсээ зөв байсныг нотлон харууллаа. Тийм болохоор тэнцвэртэй, олон тулгуурт гадаад бодлогыг бид цаашид ч тууштай баримтлах ёстой. Нөгөөх нь сүүлийн үед улс орнуудын гадаад, дотоод бодлогын зааг ялгаа илэрхий бүдгэрч байгаа явдал. Манай нөхцөлд ГХЯ зөвхөн гадаад харилцааны салбар гэлтгүй, улс орны өмнө тулгамдсан бүх асуудалд оролцдог болсон нь цар тахлын үеэс эхэлсэн харьцангуй шинэ үзэгдэл юм. Орон орны Гадаад харилцааны сайд, эрдэмтэн судлаачтай уулзаж байхад өөр өөрийн онцлог нөхцөлд бас нэг иймэрхүү сонирхолтой зүйл ажигласнаа өгүүлэх тохиолдол цөөнгүй гардаг. Олон улсын улс төр, манай үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчинд сүүлийн үед гарч байгаа өөрчлөлт, динамикийг төр, засгийн удирдлага цаг тухайд нь мэдэрч, ГХЯ нөөц бололцоогоо маш тодорхой, прагматик зорилтуудад чиглүүлж ажилласны үр дүнд 2022 онд бид томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Сүүлийн 30 гаруй жилд бид жилд дунджаар 2-3 том айлчлал хэрэгжүүлдэг байсан бол энэ жил өндөр, дээд хэмжээнд 10 гаруй айлчлал зохион байгууллаа. Хоёр хөрш, гуравдагч хөршүүдийн гадаад харилцааны зургаан сайдыг эх орондоо айлчлууллаа. НҮБ-ын

Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсад айлчиллаа. Эдгээр айлчлалын үр дүнд харилцаа, хамтын ажиллагааны олон асуудлыг нааштайгаар шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлээ. Олон улсын тавцан дахь манай улсын нэр хүнд ч мэдэгдэхүйц өссөн гэдгийг дотоод, гадаадын судлаачид, ажиглагчид онцолж байгаа.

- НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийн Монгол Улсад хийсэн айлчлал олон улсын анхаарлыг ихээхэн татах шиг болсон. Өнөөгийн олон улсын харилцааны нөхцөл байдал амаргүй байгаа талаар Та өмнө нь дурдсан. Энэхүү амаргүй үед НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга яагаад Монгол Улсад айлчлах болсон юм бэ? Энэхүү айлчлалын онцлог, ач холбогдлын талаар та танилцуулахгүй юу?

“Манай гадаад бодлогын амин сүнс нь тэнцвэртэй харилцаа” гэж би сая хэлсэн. Хоёр хөрш болон гуравдагч хөршүүдтэй харилцаа тэнцвэртэй байх ёстой. Хоёр хөршийн харилцаа бас хоорондоо тэнцвэртэй байх ёстой. Энэ бол манай үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур багана. Нөгөө нэг багана нь олон талт хамтын ажиллагаа. Дэлхий дахины болон бүс нутгийн энх тайван,

тогтвортой байдлыг сахин хамгаалах олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтад Монгол Улс өөрийн хувь нэмрийг оруулах ёстой, оролцоогоо тогтмол нэмэгдүүлэх ёстой. Монгол Улс цөмийн зэвсэггүй статусаа зарласны 30 жил, Энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойтой давхцуулан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийг эх орондоо урьж, НҮБ-ын системийн болон төрөлжсөн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагааг улам өргөжүүлэх чиглэлээр яриа хэлэлцээ хийсэн нь олон улсын улс төрийн өнөөгийн нөхцөлд ихээхэн ач холбогдолтой байсан юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсыг “Энх тайвны бэлгэ тэмдэг” хэмээсэн нь НҮБ-ын үйл ажиллагаа, түүний энхийн үйлсэд бидний оруулсан хувь нэмрийг үнэлсэн. Бас манай цөмийн зэвсэггүй статусын ач холбогдол улам нэмэгдэж байгааг харуулсан хэрэг. Энэ айлчлалаар Монгол Улсад НҮБ-ын хэрэгжүүлдэг олон улсын хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар ул суурьтай ярилцсан. Цаашид бид НҮБ-аас хэрэгжүүлж буй олон улсын хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, “НҮБ-ын



Тогтвортой хөгжлийн зорилт - 2030"-ыг Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд, түүний дотор "Тогтвортой хөгжил-2030", "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх чиглэлээр түлхүү хамтран ажиллахаар төлөвлөж байна.

- Та сая манай улсын нэр хүнд олон улсын тавцанд өсөж байна гэлээ. Яахын аргагүй манай улсыг гадаадын улс орнууд илүү сонирхож байгаа нь энэ онд хэрэгжсэн айлчлалуудаас ажиглагдсан?

2022 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас гадна НҮБ-ын ЕНБД-ын энхийн ажиллагаа хариуцсан орлогч, ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал, Канадын Парламентын Сенатын танхимын дарга, Шведийн парламентын дэд дарга, ОХУ, БНХАУ, Польш, Япон, БНСУ, Лаосын Гадаад хэргийн сайд нар, Тайландын Худалдааны сайд, Японы парламентын гишүүдийн төлөөлөл, Энэтхэгийн Хууль зүйн сайд, Батлан хамгаалахын сайд болон Үндэсний аюулгүй байдал хариуцсан орлогч дарга, Германы Холбооны Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын Хорооны дарга зэрэг өндөр албан тушаалтан айлчиллаа. Бүгд манай гадаад бодлогын болон хоёр талын харилцааны маш тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэс дараатай, давтамжтай, төлөвлөгөөтэй айлчлалууд.

Ерөнхийд нь дүгнэж хэлбэл эдгээр айлчлал манай олон тулгуурт гадаад бодлогыг баталгаажуулахын зэрэгцээ миний "амин сүнс" гэж нэрлээд байгаа харилцааны тэнцвэртэй байдлыг хадгалах чиг шугамдаа манай улс тууштай байгааг дэлхий нийтэд нотолсон хэрэг юм.

- Энэ онд манай хоёр хөрш орны Гадаад хэргийн сайд нар дараалан Монгол Улсад айлчилж, манай талаас ч өндөр дээд хэмжээний айлчлал хэрэгжүүлсэн нь анхаарал татсан. Эдгээр айлчлалуудын үр дүнгийн талаар товчхон танилцуулбал?

Өмнөд хөршид цар тахлын онцгой хатуу дэглэм үргэлжилж гадаад айлчлалыг эрс хязгаарласан хэвээр байсан ч хоёр талын харилцаа 2022 онд эрчимтэй өрнөлөө. Хамгийн сүүлд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНХАУ-д төрийн айлчлал хийж хамтын ажиллагааг бүх салбарт идэвхжүүлэн, худалдааны хэмжээг ирэх таван жилд 20 тэрбум ам.долларт хүргэхийг зорьж ажиллахаар тогтлоо. Цаашид уул уурхайн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, нүүрсээ урт хугацаанд тогтвортой экспортлох, худалдааны бүтцийг төрөлжүүлэх, газрын тосны хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүтээн байгуулалтын төслүүдийн явцыг урагшлуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг ярьж тохирсон. Мөн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бүх нийтийн үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор Ерөнхийлөгчийн санаачилсан

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хятадын тал дэмжиж хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр тохиролцсон. Айлчлалын үеэр 16 баримт бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагааны тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг тусгасан 19 заалт бүхий Хамтарсан мэдэгдэл гаргасан нь улс төр болон эдийн засгийн хувьд онцгой ач холбогдолтой үйл явдал юм. Хойд хөршийн хувьд В.Лавров сайд намар манайд айлчлахдаа Монгол, Оросын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд амжилттай хөгжиж байгааг тэмдэглэсэн, харилцан итгэлцсэн хамтын ажиллагааг бэхжүүлэх сонирхлоо хоёр тал нотолсон. Хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцааг хөгжүүлэхдээ бид эдийн засгийн гурван талт хамтын ажиллагааны санаачилгуудыг урагшлуулахыг зорьдог. Гурван улсыг холбосон "Эдийн засгийн коридор" байгуулах, манай улсаар дайруулан хийн хоолой татах, зүүн болон баруун босоо чиглэлийн төмөр зам барих, улс дамнасан авто тээврийг хөгжүүлэх зэрэг тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлд ахиц дэвшил гарч, яриа хэлцэл тасралтгүй үргэлжилж байгаа.

- Манай гадаад бодлогын бас нэгэн чухал чиглэл болох гуравдагч хөрш орнуудтай хөгжүүлж буй харилцаанд ямар ахиц, амжилт гарсан бэ. Тодорхой сорилтууд юу байв?

Хоёр хөрштэй харилцаа идэвхжихийн



**Ерөнхийлөгч
У.Хүрэлсүх
БНХАУ-д төрийн
айлчлал хийж
хамтын ажиллагааг
бүх салбарт
идэвхжүүлэн,
худалдааны хэмжээг
ирэх таван жилд 20
тэрбум ам.долларт
хүргэхийг зорьж
ажиллахаар тогтлоо.**

хэрээр гуравдагч хөршүүдтэй харилцаа ижил хэмжээнд өргөжих ёстой. Тэнцвэртэй байлгах логикийн үүднээс энэ жилийн манай гадаад арга хэмжээг координатын хавтгай дээр гурван тэнхлэгт хуваан зураглаж үзвэл энэ тэнцвэр хадгалагдаж байгаа нь илэрхий харагдах байх. Энэ жил Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Япон Улсад төрийн айлчлал хийж, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Сингапур, ХБНГУ-д айлчилсан. Японы хувьд манай Ерөнхийлөгч 12 жилийн дараа төрийн айлчлал хийлээ. Япон Улсад хийсэн айлчлал 50 жилийн түүхтэй хоёр улсын дипломат харилцааг ирэх 50 хөгжүүлэх хэтийн төлөвийг тодорхойлоход чухал ач холбогдолтой боллоо. Энэ хүрээнд хоёр

талын харилцааг шат ахиулах зорилгоор “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэл”-ийг зарлаж, хамтарсан мэдэгдэл гаргасан. Цаашид бүх салбарт хүний нөөцийг чадавхжуулах “хүн төвтэй” хамтын ажиллагаа хөгжүүлэх зорилгыг тодорхойлсон. Японы тал мөн Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж манай улсад 50 мянган мод тарих, 20 мянган хүүхэд, залуусыг танин мэдэхүйн сургалтад хамруулах зэрэг тодорхой асуудлыг ярьсан. Мөн Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Монгол Улсын эрчим хүчний хангамжийг сайжруулах төсөл” хэрэгжүүлэхээр болж ноот бичиг солилцсон. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Сингапур Улсад албан ёсны айлчлал хийж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, Сингапурын хуримтлалын сан, төрийн өмчит компаниудын засаглал, хот төлөвлөлт, нийтийн орон сууцны хөтөлбөр, цахим засаглал, мэдээллийн технологид суурилсан төрийн албаны шинэчлэл зэрэг мэдлэгт суурилсан хөгжлийн туршлагыг Монгол Улсад нутагшуулах асуудлыг хэлэлцэж хамтын ажиллагааны гурван баримт бичиг байгуулсан. Ерөнхий сайд мөн ХБНГУ-д айлчилж хоёр талын харилцааг стратегийн түншлэлийн түвшинд хүргэх талаар зарчмын хувьд тохиролцсон. Айлчлалын үеэр ХБНГУ-тай зэс боловсруулах үйлдвэр, цахилгаан автомашины гол түүхий эд болох газрын ховор элементийг хагас боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлээр судалгааны ажил эхлүүлэхээр тохирч эрчим хүч, тээвэр логистик, уул уурхай, мэдээлэл технологи, хот төлөвлөлт, хөдөө аж ахуй, ойн инженер зэрэг салбарт 1000 инженерийг үе шаттай бэлтгэх хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхээр боллоо. Мөн БНСУ-ын Гадаад хэргийн сайд Пак Жин Монгол Улсад айлчлах үеэр газрын ховор элементийн Монгол, Солонгосын хамтарсан судалгааны төв байгуулахаар болсон, үйл ажиллагаа нь эхэлчихсэн байгаа. Ярилцлагын эхэнд би “Гадаад харилцааны салбарт 2022 онд бид томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ”

гэсэн нь эдгээр тодорхой ажлуудыг хэлсэн хэрэг.

- Ирэх 2023 оны олон улсын харилцааны ерөнхий төлөв байдал ямар байх бол хэмээн харж байна?

Манай улс төр болон чиглэлийн газрууд олон улсын улс төрийн нөхцөл байдлын өрнөлт, харилцааны чиг хандлагыг ажиглаж байгаад гадаад улс төрийн орчин нөхцөлийн талаарх таамаг төсөөллийг жилээр, улирлаар гаргаж танилцуулдаг. Ингэхдээ энэ жил, энэ улиралд тэгэх төлөвтэй байна, ингэх төлөвтэй байна гэж таамаглахаасаа илүү өрнөлтийг нь дор хаяж 2-3 сценари хувилбараар төсөөлж гаргахыг хичээдэг. Олон улсын тавцанд өнөөдрийн хямрал, сөргөлдөөн урт хугацаанд үргэлжилбэл мэдээж манай гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарна. Гэсэн хэдий ч ямар ч тохиолдолд гадаад бодлогын тэнцвэртэй харьцаа хэвээр хадгалагдах ёстой. Дипломат ажил тасралтгүй, тогтмол, байнгын шинж чанараараа улам үнэ цэнэтэй болдог. Бид хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчдийн газрууд болон төвийн ажилтнуудын уулзалтын тэмдэглэл, мэдээ, илтгэх хуудас, танилцуулгад тогтмол дүн шинжилгээ хийж байж үйл ажиллагаагаа төлөвлөж, цаашдын чиг баримжаагаа тодорхойлох ёстой. Ялангуяа гадаад улс төрийн орчин тогтворгүй, олон улсын сөргөлдөөн, хориг арга хэмжээ даамжирсан нөхцөлд эдгээрээс үүдсэн зайлшгүй хязгаарлалтуудыг дүн шинжилгээний чадавхаар нөхөх оролдлого хийх нь хамгийн утга учиртай ажил болно. Иймд бид ирэх жил ГХЯ-ны дүн шинжилгээний чадавхыг бэхжүүлэх чиглэлд түлхүү анхаарах болно. Цаашид гадаад бодлогын үндсэн зарчмуудаа тууштай баримталж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа тэлж, хилийн чанад дахь Дипломат төлөөллийг жигд өргөжүүлж, хоёр хөрш болон гуравдагч түнш орнуудтайгаа тэнцвэртэй хамтын ажиллагааг улам идэвхжүүлэхэд онцгой анхаарч ажиллах шаардлагатай болж байна.



Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин,
судлаач, профессор Д.Баярхүү

“ЭНХ ТАЙВНЫ БЭЛГЭ ТЭМДЭГ” Монгол Улс

У.Хүрэлсүх Монгол төрийг тэргүүлээд жил хагасыг үдэж байна. Төрт улсын түүхээр авч үзвэл маш ахархан хугацаа. Харин энэ цаг үеийн өнцгөөс, хурдтай XXI зууны шинэ эриний дэвсгэр дээр авч яривал жил хагас гэдэг ихээхэн ажил амжуулж, амжилтад хүрчихсэн байх хугацаа юм. Түүхэн уламжлал ба орчин цагийн хослол дээр энэхүү жил хагасыг дүгнэх гэж оролдъё.

Өмнөх Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол төрийн гадаад бодлогын залгамж чанарыг алдалгүй хадгалж ирснийг үргэлжлүүлэх нь У.Хүрэлсүхийн баримтлах алтан зарчим байсныг тэмдэглэхийн сацуу өмнөх нөхрийнхөө зарим гацааг эерүүлж, гадаад бодлогын салбарыг бүхэлд нь богино хугацаанд урагшлуулахыг зорин ажиллажээ.

Ноён Х.Баттулга ба МАН-ын үнэмлэхүй олонхи УИХ, МАН-ын Засгийн газрын хооронд ил биш ч далд зөрчил оршиж байсан. Тухайлбал Монголын төрийн гадаад бодлогын алтан аргамжийг хэрэгжүүлэх учиртай Элчин сайд нарын томилгоон дээр ноён Х.Баттулга ихээхэн хатуурхаж, гацааж, үл бүтэх шаардлага, шалгуур тавьж байсныг ноён У.Хүрэлсүх эерүүлж, томилгооны гацааг гаргаж шинэ Элчин сайд нарыг ажилд нь оруулахаас

гадаад бодлогоо эхлүүлсэн билээ. Мэдээж тухайн үед нэр дэвшсэн 25 Элчин сайдыг нэг бүрчлэн шилж сонгон томилоогүй ч томилгооны гацааг гаргасан нь тухайн үедээ зөв алхам болсны сацуу хойш хойшдын томилгоон дээр зөв жишиг тогтоох эхний томхон жишиг байсан байж болно.

Дараагийн алхамд Монгол төр Ковидын жил хагасын нөхцөлд гадаад харилцаагаа үлэмж хумиад байсныг аажмаар тэлэх, идэвхжүүлэхэд анхаарч ажилласан. Гадаад харилцааны үр өгөөж, онц, санаачилга авах тал руу түлхүү анхаарсан.

Монгол төрийн тэргүүнүүдийн гадаад бодлогыг авч үзэхэд өмнөх Ерөнхийлөгч нар (тухайлбал Н.Багабанди, Ц.Элбэгдорж нар) гадаад айлчлалуудыг тултал хэрэгжүүлж, ихээхэн идэвх зүтгэл гаргаж байсныг ноён У.Хүрэлсүх илүү оновчтой болгох, үр дүн гарахгүй, эсвэл хожим үр дүн гарах айлчлалуудаас татгалзах, чухам ямар зорилгоор айлчлах, юунд хүрэх, тэр нь Монголын ард түмэн ач тусаа өгөх, нэг үгээр бол үр дүнг нь голчлон авч үзсэн нь шинэлэг үзэгдэл байлаа. Хэлбэр биш агуулга, ёслол биш бодит ажил, нэр хүнд биш гарт баригдах үр дүн гэдэг дээр түлхүү анхаарч байна.

2021 онд тэрбээр үүрэгт ажилдаа ороод гадаад айлчлалуудаа төлөвлөхдөө аль нэг гадаад хөрш

Монгол төр Ковидын жил хагасын нөхцөлд гадаад харилцаагаа үлэмж хумиад байсныг аажмаар тэлэх, идэвхжүүлэхэд анхаарч ажилласан.



хариу, Монгол-Оросын хооронд Иж бүрэн стратегийн түншлэл тогтоосны дараах анхны, бас Монгол-Оросын зуун дамжсан найрсаг харилцааны түүхт 100 жилийн ойн арга хэмжээний хаалтыг хийсэн айлчлал гэдгээрээ түүхэн ач холбогдолтой юм.

2022 онд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх гадаад айлчлалууд руу төдийлөн шимтээгүй, харин айлчлалыг хоёр урсгалтай болгох, юуны өмнө НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг эх орондоо айлчлуулах, мөн олон талт дипломат бодлогоо үргэлжлүүлэн урагшлуулах, тэр хүрээнд хоёр талын болон гурван талын харилцаагаа хөгжүүлэхэд анхаарсан. Узбекистаны Самарканд хотноо ШХАБ-ын төрийн

түнш улсыг сонголтгүй, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцохоос гадаад айлчлалаа эхлүүлсэн. Өмнөх Ерөнхийлөгч нарын үед аль нэг гадаад түнш улс сонгож айлчлахад бусад түнш улсын (ялангуяа хоёр хөрш) зүгээс эмзэглэх явдал гардаг байсныг зөв тооцоолсон. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганы дараа ч энэ зарчмаа барьсан. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний

уулзалтад (Глазгоу, Их Британи) оролцож, дэлхий нийтийн өмнө тулгарсан нийтлэг асуудлыг шийдэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн ба энэ төрлийн уулзалтад өндөр ач холбогдол өгч байгаагаа ч дараа жил нь нотолсон.

Монгол Улсын зургаа дахь Ерөнхийлөгчийн хувьд гадаад айлчлалаа 2021 оны 12 дугаар сард ОХУ-д хийсэн нь 2019 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монголд хийсэн айлчлалын



тэргүүн нарын зөвлөлийн XXII хуралдаанд ажиглагч орны Ерөнхийлөгчийн хувьд оролцоходоо хоёр хөрш орны удирдагчтай уулзаж, цар тахлын улмаас хоёр жил завсарласан Монгол-Орос-Хятадын төрийн тэргүүн нарын гурван талт ээлжит VI уулзалтад оролцож, стратегийн ач холбогдолтой “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”, “Транзит Монгол” бодлогоо таниулж, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ-д байгалийн хий нийлүүлэх хоолойн төслийн хэрэгжилтийн талаар ярилцаж, хамгийн чухал нь “Тийм. Хийг БНХАУ хүлээн авахад бэлэн байна” гэсэн үгийг Хятадын удирдагчаар зөвшөөрүүлсэн нь онцгой ач холбогдолтой болсон билээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 77 дугаар чуулганд оролцсон тухайд дайн, геополитикийн хурц зөрчил тэмцэлтэй, эсрэгцсэн, хуваагдсан энэ ертөнцөд энх амгалан хэрэгтэй байна, түүний төлөө тэмцэх хэрэгтэй гэсэн утгаар У.Хүрэлсүх даян дэлхийн энх тайвныг уриалж үг хэлсэн. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гуттерешийн Монголд айлчлахдаа бидэнд оноосон “Энх тайвны бэлгэ тэмдэг Монгол Улс” гэдэг бол зүгээр нэг нэрлэсэн биш, цаанаа гүн утга агуулгатай, тэр хэрээрээ үнэ цэнтэй, онцлогтой гэдэг утгаар төрийн тэргүүн тэгж хэлсэн болов уу. Монгол бол даян дэлхийн энх тайванд санаа тавьдаг, түүний

төлөө зовж шаналдаг, тэр хэрээрээ энх тайвны санал, санаачилга дэвшүүлдэг гэдгийн илэрхийлэл гэж үзэхээр, даян дэлхийг хамарсан бүхий л асуудалд манай улс ямар байр суурь баримталж байна вэ гэдэгт иж бүрэн хариулт өгөхийг хичээсэн, бүгдийг хамруулсан өргөн дэлгэр үг байв. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт, бие даасан гадаад бодлогыг тууштай явуулж ирсэн, цаашдаа ч тэгнэ гэсэн итгэлээ дахин нотолсон нь тэр байв.

Өмнөх жил Глазгоуд болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтын дараагийн уулзалт (COP27) Египет Шарм Эль-Шейхэд зохиогдоход Ерөнхийлөгч оролцсон. У.Хүрэлсүх уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх, дэлхийн дулаарлыг сааруулах чиглэлээр Монгол Улсын баримталж буй байр суурийг илэрхийлж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулж, “Тэрбум мод” хөтөлбөрөө сурталчилсан. Мөн зарим улсын төрийн тэргүүн болон олон улсын байгууллагуудын удирдлагуудтай хоёр талын уулзалт хийсэн.

2022 оны хувьд төрийн тэргүүний гадаад айлчлалуудын оргил нь оны төгсгөл хавьд хэрэгжүүлсэн БНХАУ, Японд хийсэн төрийн айлчлал байв.

Цаг үеэ олсон, хоёр хөрш ба гуравдагч хөршүүдийн хоорондын тэнцвэр хангасан, зээл тусламжийн агуулгатай явж ирсэн

харилцааг харилцан нөхсөн, худалдаа-хөрөнгө оруулалтын, мөн монгол хүний хөгжлийн агуулгатай болгосон хоёр айлчлал хэмээн үзэж болно.

2022 оны хувьд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар нэг жилд хоёулаа БНХАУ-д албан ёсоор айлчилсан, БНХАУ-ын хууль тогтоох дээд байгууллагын дарга, Гадаад хэргийн сайд (Төрийн Зөвлөлийн гишүүн) манай эх орныг зориод ирсэн, ялангуяа төрийн тэргүүний албан ёсны төрийн айлчлал угтуулаад цахимаар салбар салбарын сайд нар хамтран хуралдаж хэлэлцэх, гарын үсэг зурах бүх асуудал, баримт бичгээ харилцан тохиролцсон тохиолдол тэр болгон давтагдаад байдаггүй. Дэлхийг зогсонги байдалд оруулсан цар тахлын хоёр жилийн дараа, БНХАУ-ын дотоод амаргүй улс төрийн үйл явцын дараа, ХКН-ын XX Их Хурлын дараа манай Ерөнхийлөгч айлчилсан нь хоёр талдаа улс төрийн өндөр ач холбогдолтой үйл явдал байв. Хоёр тал энэ айлчлалд маш их ач холбогдол өгсөн. Тэгэх тусмаа хоёр сар хагасын дотор хоёр төрийн тэргүүн албан ёсоор хоёр удаа уулзсан, хоёр улсын хооронд бусдад жишиг болох үлгэр жишээ харилцаа болгохын төлөө хоёул нэгэн санаагаар тэмцсэн, Иж бүрэн стратегийн түншлэлээ шинэ шатанд гаргасан, манай улсад ашигтай байдлаар худалдаа-эдийн засгийн харилцааг хөгжүүлж, худалдааны эргэлтийг 20 тэрбум ам.долларт хүргэхээр



Монгол-Япон хоёр цаашдын 50 жилээ урьдчилан харсан, тэгэх тусмаа ойрын 10 жилд хамтран хэрэгжүүлэх ажил үйлсээ томъёолсон, тэр дундаа Монгол Улс, монголчуудын хөгжил дэвшилд түлхэц үзүүлэх, монгол хүн рүү чиглэсэн хөрөнгө оруулалт хийх зэрэг олон чухал ажлыг эхлүүлэх болжээ.

тохиролцсон гэдгээр 2022 он түүхэнд нэн чухлаар тэмдэглэгдэнэ. Жагсаавал олон салбар буй, худалдаа-эдийн засаг, эрчим хүчний хамтын ажиллагаа, нүүрсний худалдаа, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн бүтээн байгуулалтууд гээд ярьвал баярлуулах мэдээ (Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг шинэ эрин үед урагшлуулан хөгжүүлэх тухай Монгол Улс, БНХАУ-ын Хамтарсан мэдэгдлээс харна уу) олонтой буцаж ирсэн. Хятадтай нүүрсний урт хугацааны хамтын ажиллагаа явуулах ба жилдээ 40-70 сая тонныг Хятадад худалдана гэдэг дээр манай тал зогссон. 2019 онд түүхэндээ хамгийн их буюу 31 сая тонныг экспортолж байсан бол 2-3 дахин өсгөхөөр хоёр төрийн тэргүүн ярьж тохиролцов. Холболтууд хийгдэнэ. Төмөр замаа өөрсдөө барьж босгоод хил рүү хүргэхийг Хятадад өндөр үнэллээ. Холболтоор хилийн нэвтрүүлэх чадвар нэмэгдэнэ. Манай улс тавьсан зорилгодоо хүрнэ. Хоёр орны худалдаа ч шинэ шатанд гарна.

2022 оны төгсгөлийн айлчлал. “Монгол Улс, Япон Улсын энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийг хөгжүүлэхэд чиглэсэн Хамтарсан мэдэгдэл гаргасан. Стратегийн түншлэлийн дараагийн дээд шат нь “Иж бүрэн” гэх тодотголтой байх учиртай бол, бид хамтдаа “алтан дундаж”-ийг олоод “тусгай” гэсэн тодотгол хийсэн.

Хоёр хөршдөө хар суулгахгүй, гэхдээ Монгол Улсын гадаад бодлогод гурвуулаа нэг зиндаанд гэж ойлгогдохоор “алтан дундаж”-ийг зөв томъёолсон.

Японы Ерөнхий сайдтай хийсэн хэлэлцээ, хамтарсан хэвлэлийн хурал, Хамтарсан мэдэгдэл, Японы Эрхэм Дээд Эзэн хаантай уулзсан, тэгэх тэгэхдээ нэг өдөрт зургаан удаа уулзана гэдэг, Морин хуурын чуулгын сэтгэл догдлом тоглолтыг Японы Эрхэм Дээд Эзэн хаан, Эрхэм Дээд Хатан таалан соёрхоно гэдэг тэр бүр тохиолддоггүй “үзэгдэл” гэж японы албаны хүмүүс бахдан тэмдэглэж байв.

Манай улс хоёр их хөршөөр хүрээлэгдсэн (нэг ёсондоо хашигдсан), тэр хоёр нь нийгмийн байгуулал ба улс төрийн тогтолцооны хувьд ардчилсан Монголтой тэр бүр авцалдах албагүй, гэтэл газар зүйн онцлогоо үл харгалзан монголчууд эрх чөлөө, ардчилал, хүний эрх, хуулийн засаглал зэрэг үнэт зүйлсээ хамгаалж, олон улсын хамтын нийгэмлэгт хувь нэмрээ оруулан, нэр хүндтэй байр суурь эзэлсээр ирснийг Япон өндрөөр үнэлсэн. Нийтлэг үнэт зүйлстэй түнш улс орнуудын хувьд “эрх чөлөө, ардчиллын мөн чанар”-ыг хадгалж, харилцан ашигтай хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлж, хамтдаа хөгжих хүсэл эрмэлзэлтэйгээ нотлов гэсэн нь нэг ёсны улс төрийн өндөр үнэлгээ юм.

Монгол-Япон хоёр цаашдын 50 жилээ урьдчилан харсан, тэгэх тусмаа ойрын

10 жилд хамтран хэрэгжүүлэх ажил үйлсээ томъёолсон, тэр дундаа Монгол, монголчуудын хөгжил дэвшилд түлхэц үзүүлэх, монгол хүн рүү чиглэсэн хөрөнгө оруулалт хийх зэрэг олон чухал ажлыг эхлүүлэх болжээ. Энэ мэт олон баримт дурдаж болно. 2023 ондоо ч энэ зөв эхлэлүүд үргэлжилнэ гэдэгт итгэл төгс байна.

ТӨГСГӨХ ҮГС

Миний бие Элчин сайд байсны хувьд, одоо гадаад бодлогын эксперт байгаагийн хувьд Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн хэд хэдэн айлчлалд хамт оролцож, дагалдан явлаа. Үүнд 2021 онд ОХУ-д, 2022 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган, мөн БНХАУ, Японд хийсэн төрийн айлчлалууд болно. Албан ёсны гурван айлчлал, мөн Олон улсын хамтын нийгэмлэгт айлчлахад нь ажигласан зүйл бол миний дээр томъёолсон “Хэлбэр биш агуулга, ёслол биш бодит ажил, нэр хүнд биш гарт баригдах үр дүн” гэдэгтээ ихээхэн ач холбогдол өгдөг, ажлыг шуурхай амжуулдаг, шуурхай шийддэг, түс тас, ил тод, дайчин чанар ноён У.Хүрэлсүхэд харагдаж байсныг тэмдэглэх нь зөв болов уу.

ШУА-ИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ, ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР Д.ЗОЛБОО

Ерөнхийлөгч ба гадаад бодлого



- Танд энэ өдрийн мэнд хүргэе. Аливаа улс орны гадаад бодлого хэрхэн тодорхойлогдож, хэрэгждэг талаар товч тайлбарлаж өгнө үү?

Хүн төрөлхтөн төрийн эрх мэдлийн хуваарилалтыг онолын түвшинд боловсруулан хөгжүүлсээр ирсэн бөгөөд өнөөдөр аливаа төр, нийгмийн эрх мэдлийн хуваарилалт Үндсэн хууль зэрэг тулгуур баримт бичигт тусгагдах болсон байна. Нийгмийн бүхий л асуудлыг хамарсан эрх мэдлийн хуваарилалтад тухайн улс орны гадаад бодлого, гадаад харилцаанд хамаарах эрх үүрэг тусгалаа олдог болсон байна.

Манай улсын хувьд 1992 онд батлагдсан Үндсэн хуульдаа нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг баримталж,

энхийг эрхэмлэсэн гадаад бодлого баримтлахаар заасныг бид бүхэн мэднэ. Харин энэхүү энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэхдээ төрийн эрх мэдлийн хуваарилалтын дагуу Үндсэн хуулийн институциудын гадаад бодлого, гадаад харилцаанд холбогдох эрх үүргийг товч боловч тодорхой зааж өгсөн. Тухайлбал, Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд Улсын Их Хурал нь гадаад асуудлыг санаачлан хэлэлцэж болно, төрийн гадаад бодлогын үндсийг тодорхойлох, гадаад улстай харилцаа тогтоох, цуцлах эрхтэй байдаг. Түүнчлэн Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд Засгийн газар нь төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх бүрэн эрхтэйг хоёргүй утгаар зааж өгсөн байдаг. Харин гадаад харилцааны асуудалд Ерөнхийлөгч дээрх хоёроос ялгаатай эрх, үүрэгтэй

болохыг Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд томъёолжээ. Тэр нь юу хэмээвээс, Ерөнхийлөгч нь гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах эрхтэй, мөн гадаад улсад суух Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татахад УИХ-тай зөвшилцөх, гадаад улсын Бүрэн эрхт төлөөлөгчийн тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах, жуух бичгийг хүлээн авах эрхтэй гэж заасан байдаг. Түүнчлэн Ерөнхийлөгч бол гадаад бодлого, гадаад харилцааны чиглэлд голлох шийдвэр гаргах субъект мөн гэдгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэгийнх нь хувьд бас харж болно. Гэхдээ гадаад харилцаа, гадаад бодлого хэмээх их ай сав дахь аливаа түүхэн шинжтэй алдаа, оноог хэн нэгэн хувь хүнд шууд хамаатуулах, нялзаах нь судлаач хүний ажил биш. Товчхон дүгнэхэд, шинэ Үндсэн хууль хүчин төгөлдөр хэрэгжсэн сүүлийн хагас жарны хугацаанд хамгийн тогтвортой хөгжсөөр ирсэн салбар бол гадаад бодлого, гадаад харилцааны салбар мөн гэж үздэг эрдэмтэн судлаачид, ахмад дипломатуудын дүгнэлттэй санал нэг байна. Ямар боловч манай улс гадаад ертөнцтэй нэг цонхоор харилцаж чадаж байгаа нь Ерөнхийлөгчийн институцид хадгалагдсан гадаад харилцаа, гадаад бодлогын эрх, үүрэг ба тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой эерэг үзэгдэл, үр дүн хэмээн үзэж болох юм.

- Судлаачид Монгол Улсын өмнөх Ерөнхийлөгч нарын гадаад бодлого, харилцааны чиглэлд гүйцэтгэсэн үүргийг хэрхэн үнэлдэг вэ?

Монгол Улсын өмнөх таван Ерөнхийлөгч дээр дурдсан гадаад бодлого, харилцааны чиглэлд холбогдох эрх, үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр түүхэн цаг хугацаандаа өөр өөрийн үүргээ гүйцэтгэсээр ирлээ. Сүүлийн 30 гаруй жилийн гадаад харилцааны түүхийг Ерөнхийлөгч нарын хувь хүний болон институцийнх нь гүйцэтгэсэн үүрэг, оролцоог тодорхойлж, үнэлэлт дүгнэлт

өгсөн судалгааны өгүүлэл, бүтээл цөөнгүй гарсан. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалыг анхлан боловсруулах, хожим шинэчлэн боловсруулахад тэдний оролцоо ямагт чухалчлагдаж байсныг хэн ч үгүйсгэх аргагүй юм. Энэ талаар гадаад, дотоодын судлаачдын бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлийг манай хүрээлэнгийн “Олон улс судлал” зэрэг сэтгүүлээс үзэж, танилцах боломжтой. Ерөнхийлөгчийн Тамгын газраас эрхлэн 2015 онд хэвлэгдсэн “Монгол Улсын Ерөнхийлөгч 25 жил” гэдэг он дарааллын товчоон их сайн сурвалж болж үлдсэн. Та бүхний гаргаж буй энэхүү сэтгүүл ч түүхэн цаг хугацааны дараа бас нэгэн чухал эх сурвалж болон үнэлэгдэнэ гэдэгт итгэлтэй байна.

- Таны хувьд Монгол Улсын өнөөгийн гадаад бодлогын чиглэлд ямар өөрчлөлт гарч байна гэж үзэж байна вэ?

Одоогийн Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн бүрэн эрхийн хугацааных нь дөнгөж гуравны нэг нь өнгөрч байгаа тул бүхэлд нь үнэлэлт дүгнэлт өгөхөд эрт байна. Олон улсын нөхцөл байдал өмнөх аль ч Ерөнхийлөгчийн үеийнхтэй харьцуулахын аргагүй эрс ялгаатай, цочмог өөрчлөлтийн дунд өрнөж байгааг тэмдэглэх ёстой. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын аюул намжиж амжаагүй байхад Орос-Украины дайн, үүнээс үүдэлтэй их гүрнүүдийн эрх ашгийн сөргөлдөөн улам бүр гүнзгийрсээр байна. Хүн төрөлхтөн гэнэтийн байгалийн ноцтой үзэгдлийг урьдчилан мэдэж чаддаггүй нүүр тулмагц хүчин мөхөстдөгийн нэгэн адил, олон улсын харилцааны нөхцөл байдал хэрхэхийг урьдчилан тааварлахад тун амаргүй, төвөгтэй байдаг л даа. Яаж ч эргэж мэдэх ийм төвөгтэй гадаад орчинд манай улс энхийг эрхэмлэсэн олон тулгуурт гадаад бодлогоо тууштайгаар, тогтвортойгоор баримтлах нь чухал юм. Ямар боловч хоёр хөрштэй харилцах манай харилцааны шинэ түвшин, хэсэг тасалдсан манай төрийн тэргүүний НҮБ-ын индэр дээрээс дэлхийн улс орнуудад зарласан “Тэрбум

Одоогийн Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн бүрэн эрхийн хугацааных нь дөнгөж гуравны нэг нь өнгөрч байгаа тул бүхэлд нь үнэлэлт дүгнэлт өгөхөд эрт байна. Олон улсын нөхцөл байдал өмнөх аль ч Ерөнхийлөгчийн үеийнхтэй харьцуулахын аргагүй эрс ялгаатай, цочмог өөрчлөлтийн дунд өрнөж байгааг тэмдэглэх ёстой.

мод” үндэсний хөдөлгөөн гээд олон зүйлийг дурдаж болно.

- Монгол Улсын гадаад орчин, олон улсын харилцааны нөхцөл байдал хөгжлийн ямар чиглэлд өрнөж байна вэ?

“Хүн төрөлхтний түүхэнд алтан үе гэж байгаагүй, цаашдаа ч байх боломжгүй” гэсэн нэг чухал ойлголт байдаг даа. Тиймээс цаг үе бүхэн өөр өөрийн асуудал, сорилттой тулгарч, шийдлээ олсоор маргааштайгаа золгосоор байдаг, тийм ч байх болно. Нэгэн сэтгэгчийн “Мөнхийн анд нөхөр, дайсан гэж үгүй харин мөнхийн эрх ашиг л гэж бий” гэж хэлсэнчлэн Монгол Улс тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бататгахад нэн тэргүүнд гадаад бодлогын ухаалаг байдал юу юунаас эрхэм болж байна. Гадаад орчин, дэлхийн байдал улам бүр адармаатай болсоор байна. Чухам ийм цагт Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа шинэчлэн боловсруулах талаар яриа санаачилга өрнөж, эрдэм шинжилгээний байгууллагуудаас албан ёсны дүгнэлт гаргуулж авч байгаад бид ихэд олзуурхаж байна. Аливаа шийдвэрийг гарсных нь дараа шүүмжлэн буруушаах биш, харин “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй” зарчмаар шийдвэр гарвал алдаа мадаг багатай байх нь дамжиггүй. Тэгээд ч өнгөрсөн жил шинэчлэн байгуулагдсан ҮАБЗ-ийн Шинжээчийн хэсэгт ШУА-ийн болон холбогдох их, дээд сургуулийн хүрээлэнгүүдийн удирдлага, төлөөлөл багтсан нь гадаад бодлого зэрэг чухал салбарын шийдвэр гаргалтад эрдэмтэн

судлаачдын дуу хоолойг сонсох, баримт бичигт тусгахад илүү анхаарч байгаа юм уу гэж анзаарагддаг. Түүнчлэн гадаадад суух Элчин сайд нарын томилгоо тодорхой хэмжээнд “нүдээ олж” байгаа нь хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагаанд гарч буй нааштай өөдрөг үр дүнгээс харж болно л доо. Үндэсний аюулгүй байдлын тулгуур зарчим болох нэг улсаас хэт хараат байхаас аль болох зайлсхийн хөрш орнуудтай тэр дундаа “Гуравдагч хөрш” орнуудын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь юу юунаас чухал болсоор байна.

- Ярилцлагынхаа төгсгөлд гадаад бодлого, харилцааны чиглэлээр хийж хэрэгжүүлэх шаардлагатай ямар ажил байна гэж боддог талаар сонирхож асуумаар байна?

Дэлхий дахины улс төр болон технологийн хурдацтай хөгжлийн дагуу үндсэн баримт бичгүүдээ яаралтай шинэчлэн боловсруулах шаардлагатай болов уу. Бас нэг зүйлийг сонирхуулахад одоогоос 10 гаруй жилийн өмнө УИХ-ын гишүүнагсан М.Батчимэг нарын санаачлан өргөн барьсан Гадаад харилцааны тухай хууль шиг баримт бичигтэй болж чадвал олон зүйл тодорхой болж, эвэндээ орох үүд нээгдэж болох юм. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэх асуудал ч идэвхтэй яригдах болж, эхний үр дүн нь удахгүй гарна гэдэгт итгэлтэй байна.

- Цаг гарган ярилцсанд баярлалаа.



Нийтлэлч:
О.Түвшиндэмбэрэл

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Монгол Улсын гадаад харилцааг нэн шинэ түвшинд гаргалаа



Монгол Улс нь нээлттэй, энх тайванч, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого баримталдаг. Энэ бодлогоо идэвхжүүлэх талаар Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх онцгой анхаарч ажиллаж ирсний үр дүнд 2022 онд гадаад харилцааны олон ахиц дэвшил гарсан. Монгол Улс нь цар тахал болон дайны тулгамдсан асуудалтай хөршүүдтэйгээ харилцаагаа тэнцвэржүүлэх дэлхийн улс орнууд болон НҮБ-д Монгол Улсынхаа оролцоог нэмэгдүүлэх, бүс нутгийн хэмжээнд улсынхаа амбиц, эдийн засгийн хамтын ажиллагааны олон талт боломжоо таниулах гээд олон ажил хүлээгдэж байсан. Хатуухан хэлэхэд монголчууд гадаад харилцааг аль нэг улсаас зээл тусламж олж ирэх, өндөр дүнтэй мөнгө босгох төдийд иргэд бид ойлгож явж ирсэн. Өнгөрсөн жилүүдэд ч гадаадад айлчилсан дарга сайд нарын гуйвар гуйлга ийм ойлголтыг иргэддээ өгчихсөн. Хамгийн ойлгомжгүй нь гадаад бодлого нь дур зоргоороо хэн

дуртай нь Монгол Улсыг төлөөлөн нэгнээ үгүйсгэх өмнөх яриа уулзалт хэлэлцээ хийсэн Засгийн газар, сайд нар нь огцорч яриа хэлэлцээр бүтэлгүйтэх, ажил хэрэгч асуудлууд замхрах, эзэнгүйдэх гээд олон алдаа дутагдал байсан. У.Хүрэлсүх Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон цагаасаа дээрх алдаануудад дүгнэлт хийж маш богино хугацаанд Монгол Улсын гадаад харилцааг нэг цонхоор хандуулж чадсан. Улс орны гадаад харилцаа эмх цэгц, эрэмбэ дараатай болгон ажилласнаар улс орнууд Монгол Улсад хандах хандлага өөрчлөгдөж байна. Иймээс өнгөрсөн жилийг Монгол Улсын гадаад харилцаанд ахиц гарсан жил гэж дүгнэж болно. Гадаад нэр хүнд шинэ түвшинд хүрсэн. Хөрөнгө оруулалт, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийн эхлэлийг тавьсан. Олон улс оронтой өргөн хүрээнд ажил хэрэгч, эдийн засгийн хөгжлийн хамтарсан гэрээ, хэлцэл яригдаж эхэлсэн он байлаа.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Монгол Улсын байр суурийг олон улсад тодорхой, иргэддээ ойлгомжтой байдлаар илэрхийлсэн

“Монгол Улс нь ШХАБ-д элсэх нь ээ. Цаашлаад бүр ТУХН-ын гишүүнээр элсэх гэнэ” гэж цуурч, элссэн нь буруу зөв гэх таамаг, хардлага иргэдийн дунд маргаан, мэтгэлцээн болж эхэлж байсан нь саяхан. Ийм байдал хоёр хөршдөө ч эргэлзээ төрүүлж холын улс гүрнүүдэд ч тодорхойгүй байдал үүсгэж байсан биз. Энэ эргэлзээг Монгол Улсын Ерөнхийлөгч

У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Узбекистан Улсын Самарканд хотноо болсон ШХАБ-ын уулзалт дээр “Монгол Улс бол ардчилсан улс бид иргэдийнхээ саналыг хүндэтгэн үздэг тогтолцоотой.

Иймд Монгол Улс ШХАБ-д цаашид ажиглагчийн байр сууриа хэвээр хадгална” гэдгээр шулуухан илэрхийлсэн. Түүний энэ үг Монгол Улс нь аливаа цэргийн эвсэл, улс төрийн чиг хандлагатай олон улсын байгууллагад элсэх асуудалд аль нэг улсын шахалт ятгалгад автахгүй гэдгээ эрс тодорхой ойлгуулсан дипломат илэрхийлэл гэдгийг хөршүүдээс эхлээд олон улсын түвшинд анзаарсан, ойлгосон гэдэг нь эргэлзээгүй. Тийм ч учраас Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Монгол улс цаашид ШХАБ-ын гишүүн орнуудтай худалдаа, хөрөнгө оруулалт, эрчим хүч, тээвэр ложистик, байгаль орчин, аялал жуулчлал, мэдээллийн технологи, хөдөө аж ахуй, хүнсний хангамж-аюулгүй байдал, хүмүүнлэгийн салбарт хамтын ажиллагаа агаа улам өргөжүүлэн хөгжүүлж, улс хоорондын болон бүс нутгийн эдийн засгийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх, бодит ажил хэрэг болгох саналыг ШХАБ-ын улс орнууд дэмжиж хүлээн авсан. Монгол Улс нь төвийг сахисан, энх тайвныг илэрхийлэгч, зөвхөн дэлхий нийтийн амар амгалангийн үйл хэрэгт НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцдог гэдгээ нотолсон хэрэг юм. Ер нь зарим асуудалд Монгол Улсын байр суурийг ингэж шулуун ойлгуулах нь хамгийн зөв гэдгийг Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн энэ илэрхийлэл тодорхой харуулсан. Монголчууд нялуунаас шулуухан нь дээр гэж эртнээс хэлц болгож ирсэн энэ үг ШХАБ-ыг тойрсон эргэлзээг гадаад болон дотоод орчиндоо эцэс болгосон эрс шийдмэг хариулт болж чадсан.



Монгол Улсын зочин хойморт тухалсан НҮБ-ын тэргүүний дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх цөлжилттэй тэмцэх үйлсэд улсынхаа бодит оролцоог оруулж “Тэр бум мод” тарьж ургуулах зорилт тавьж. Улс орнуудад ногоон хөгжилд хамтрах саналаа илэрхийлэн, хүн төрөлхтний хүнсний хомсдол, аюулгүй байдалд улс орнууд онцгойлон анхаарах ёстойг сануулав. Дайн тулаан, үл ойлголцолтой дэлхийн өнөөгийн байдалд шүүмжлэлтэй хандаж эртний түүхт Их Монгол Улсын амар амгаланг эргэн сануулсан уриалгаар НҮБ-д ойрын жилүүдэд эзэнгүйдсэн суудлыг амь оруулсан төдийгүй энх тайвныг илэрхийлэгч, ардчилсан нээлттэй Монгол Улсыг олон улсын анхаарлын шинэ түвшинд гаргасан юм. Үүний үр дүнд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш Монгол Улсад айлчлахдаа “Монгол бол энх тайван, амар амгалангийн бэлэг тэмдэг болсон улс” хэмээн онцлон тэмдэглэсэн. Өнгөрсөн онд НҮБ-тай хамтарч Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн олон улсын их хурлыг амжилттай зохион байгуулж, хуучин нисэх буудлыг НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр ашиглах, 2026 онд Дэлхийн уур амьсгал цөлжилттэй тэмцэх хурлыг Монгол Улсад зохион байгуулах, цөлжилтийн эсрэг “Тэрбум мод”, хүнсний аюулгүй байдал, эрүүл хүнс үйлдвэрлэлийн салбарт хамтрах зэрэг гол ажлаа тодорхойлон тохирсон юм.



Зан сайтай айлд хүн зон цуглана

Өрх гэрийн тэргүүн нь хэрцараатайгаас шалтгаалж хотол түмэнд тухайн айлын нэр хүнд хөрш саахалт, ус нутагтаа үнэлэгддэг. Тухайн айл өрхийн амьдрал ахуй, ашиг өгөөж ч арвижин дэлгэрч, өрх гэртээ шингэж байдаг. Хөрш зэргэлдээ айл саахалт, хүн зоноос дөлсөн өрх гэр эзгүйрэн зожирч ертөнцийн хөгжил, дэлхийн соёлоос гээгддэг.

У.Хүрэлсүх Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон цагаас энэ тал дээр маш ончтой ажиллаж байгаа гэвэл зохино. Монгол Улс дэлхийн аль ч орны хувьд үл ойлгогдох зүйлгүй. Улс төр, эдийн засгийн хувь харилцахад таамаглах шаардлагагүй. Хамтран ажиллаж харилцаагаа тодотгосон нээлттэй улс бол Монгол Улс юм гэсэн эргэлзээгүй байр суурийг бусад улс орнуудад өгч чадсан явдал нь Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн гадаад харилцааны бодлогын том амжилт юм. Энэ амжилтыг бататгаж өнгөрөгч онд Монгол Улсад

дэлхийн нөлөө бүхий улс орнууд болох Япон Улсын Гадаад хэргийн сайд Хаяаши Ёшимаса, ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И, Польшийн Гадаад хэргийн сайд Збигнев Рау, Энэтхэгийн Хууль зүйн сайд Кирен Рижижу, Канад Улсын Гадаад хэргийн яамны Хойд Азийн орнууд хариуцсан газрын захирал Уэлдон Эпп, Шведийн Хаант Улсын парламентын тэргүүн дэд дарга Оса Линдестам, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн яамны Ази, Ойрх дорнодын асуудал хариуцсан төрийн сайд Аманда Миллинг, ХБНГУ-ын Холбооны Зэвсэгт Хүчний Жанжин штабын дарга, генерал Эбэрхард Цорн, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын энхийн ажиллагаа хариуцсан орлогч Жан Пьер Лакруа, НҮБ-ын Хүүхдийн сангийн

Зүүн Ази, Номхон далайн бүсийн захирал Дэбора Комини, ЮНЕСКО-ийн ерөнхий захирал Одри Азулей нарын Монгол Улсад хоёр хөршөөс гадна гуравдагч хөрш орнуудын өндөр дээд албан тушаалтнуудын айлчлал амжилттай болж өнгөрлөө.

Монгол Улс нь жилд дунджаар 2-3 томоохон айлчлал хэрэгжүүлдэг байсан бол 2022 онд өндөр, дээд түвшинд 10 гаруй айлчлалыг хүлээн авч гадаад харилцаагаа тэлсэн. Харилцан ашигтай хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг баталгаажуулсан байдаг. Зан сайтай айлд хүн цуглана. Зон олонтой айлын зорилго зорилт биелнэ. Эргэлзэх хэрэггүй ойлголт юм. “Хүн хүнийхээ хүчинд загас усныхаа хүчинд” гэсэн зуун зууныг элээсэн үгийн үнэн өнөөгийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн явуулж буй гадаад бодлогоос харагдах цаг удахгүй.



Монголчууд дэлхий ертөнцийн амаргүй шалгуурыг, засаглалын тогтвортой байдал, гадаад харилцааны ончтой бодлогоор давж байна

Дайн тулаан, өвчин тахал, дэлхий нийтийн эдийн засгийн уналтаас шалтгаалсан улс орнуудын тогтворгүй байдал. Дэлхий нийтийг хамарсан иргэдийн бухимдал, сэтгэл зүйн цочролтой цаг үе. Жагсаал, тэмцэл хөдөлгөөн хаа сайгүй өрнөсөн маш эмзэг нөхцөл байдлыг Монгол Улс нь дотооддоо засаглалын тогтвортой байдал, гадаад орчиндоо олон талт тэгш харилцааг эрчимтэй өрнүүлж чадаж байгаа нь олзуурхууштай.

Монгол улс гадаад ертөнцөд олон тулгуурт гадаад харилцаагаа тэнцвэртэй явуулж чадсаны үр дүн ч гарч байна. Дэлхийн тэргүүлэгч улсуудтай эдийн засгийн хамтарсан олон асуудлаар харилцан тохирч чадсан. Ирэх он жилүүдэд олон салбарыг хамтарсан төсөл хөтөлбөр, экспорт импорт, худалдааны эргэлт өсөж, улсын эдийн засаг тэлэх нь тодорхой боллоо. Хандив, тусламж царайчлах биш хамтын ажиллагаа, хамтарсан төсөл хөтөлбөр, харилцан ашигтай эдийн засгийн олон салбарын үйл ажиллагааг Монгол Улсын зүгт татсан Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн

хүчин чармайлт цаашид Монгол руу хандах эерэг олон ахиц дэвшлийг авч ирэх эхлэлээ тавьчихлаа.

Ийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх цар тахлын дараах анхны айлчлалаа хоёр хөршдөө хийж, тэд ч дэлхийг хамарсан тахлын дараах анхны айлчнаар манай Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарыг өндөр, дээд хэмжээнд хүлээн авлаа. Монгол Улсын хувьд хоёр хөрш болон гуравдагч хөршүүдтэйгээ ойрын 5-10 жил хамтран ажиллах улс төр, эдийн засгийн нэгдсэн ойлголтод хүрч хамтран хөгжих, харилцан ажиллах Замын зургаа бүрэн тохирсон.

Хилийн боомтуудын нэвтрэх чадварыг нэмэгдүүлэн, төмөр замын холболтыг эцэслэн шийдвэрлэж Евроазийг холбох авто тээвэр, төмөр замын төсөл бүхий “Эдийн засгийн коридор” байгуулах, нүүрс болон уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, эрчим хүч, дэд бүтцийн салбарт хамтран ажиллах гээд гурван улс хоорондын төдийгүй бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах боломж

нөөцөө бүрэн тодорхойлсон. Монголчууд гуравдагч хөршүүдтэйгээ нүүрсний гүн боловсруулалтын технологийн салбарт хамтран ажиллаж шингэрүүлсэн нүүрсний шинэ технологи нэвтрүүлэх, газрын ховор элемент түшиглэсэн хамтарсан үйлдвэрлэл хөгжүүлэх, боловсрол, хүний хөгжил, анагаах ухаан, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуйн салбарт улс орнуудтай өргөн хүрээнд хамтран ажиллах судалгаа шинжилгээний болон бусад олон ажлуудыг эхлүүлж байна. Одоо монголчууд гадаад ертөнцөд харилцан ашигтай байх зарчимд суурилсан саналуудыг тавьдаг болсон.

Зээл, тусламж хүсдэг биш хамтын ажиллагаа боломж санал болгодог бүс нутаг, тив дэлхийн эрх ашигт өөрийн орны оролцоо, эн тэнцүү байр суурь илэрхийлдэг, эдийн засаг, худалдаа арилжаа, эрчим хүч, уул уурхай, тээвэр ложистк зэрэг олон талт өргөн хүрээний төсөл, хөтөлбөрт ажил хэрэгч түншлэгч орон гэсэн шинэ ойлголтыг өгсөөр Монгол Улсын гадаад харилцаа эрчимтэй урагшилж эхэллээ.

